TDB
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ХӨГЖИЛД ХАМТДАА

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр

АГУУЛГА

X4 • Хурлын зар

X7 • Хурлын хөтөлбөр

X9 • Хурал хуралдуудах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

X10 • Тооллогын комиссын бүрэлдэхүүн

X11 • Хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалт, танилцах журам

X12 • Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан

X72 • 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын байгууллагын дүгнэлт

X89 • Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт

X94 • Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоол

X96 • Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга

X98 • Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслүүд

X105 • Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 12 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлаж байна.

1. Компанийн оноосон нэр, хаяг:	"Худалдаа, хөгжлийн банк" ХК Улаанбаатар хот, 14210, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, Худалдаа, хөгжлийн банкны төв байр
2. Хурал хуралдах газар, өдөр, цаг:	2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 09 цаг 00 минутад Худалдаа, хөгжлийн банкны боловсруулсан цахим хуудас болох investor.tdbm.mn-ээр дамжуулан цахим буюу зайны технологи ашиглан хуралдуулах.
3. Хуралд оролцох хэлбэр:	Цахим /зайнаас/
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:	2025 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр

5. Хурлаар хэлэлцэх асуудал:

- Танилцуулах асуудал:
  - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлан;
  - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
  - Ногдол ашиг хуваарилах тухайн ТУЗ-ийн шийдвэр.

- Хэлэлцүүлэх асуудал:
  - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
  - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай;
  - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай.

6. **Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:**

- Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
- 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын байгууллагын дүгнэлт;
- Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоол;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах "Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай" тогтоолын төсөл;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах "Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай" тогтоолын төсөл;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах "Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай" тогтоолын төсөл;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас.

7. **Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид хурлын материал болон холбогдох бичиг баримттай танилцах журам:**

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид дараах арга, хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн танилцаж болно. Үүнд:

- Худалдаа, хөгжлийн банкны investor.tdbm.mn цахим хаягт хандан танилцах;
- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандан танилцах;
- Худалдаа, хөгжлийн банкны төв байранд ажлын өдрүүдийн 10:00-17:00 цагийн хооронд Хурал зохион байгуулах комисст хандан танилцах.

8. **Хуралд оролцох, санал өгөх заавар:**

Хувьцаа эзэмшигч Та дараах аргуудын аль нэгээр хуралд оролцож санал өгөх боломжтой. Үүнд:

Цахимаар оролцох:

- Хуралд зайнаас оролцох хувьцаа эзэмшигчид 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 8 цаг 45 минутаас өмнө investor.tdbm.mn цахим хуудаст хандан зааврын дагуу хуралд цахимаар оролцож, саналаа өгнө.

Урьдчилсан санал өгөх:

- Цаасан хэлбэрээр санал өгөх: Саналын хуудсыг 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 17:00 цаг хүртэл Худалдаа, хөгжлийн банкны төв байранд Тооллогын комисс хүлээн авна.
- Цахим хэлбэрээр санал өгөх: Худалдаа, хөгжлийн банкны investor.tdbm.mn цахим хуудсанд хандан 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 17:00 цаг хүртэл саналаа өгөх боломжтой.

9. Хурал зохион байгуулах болон Тооллогын комисстой холбоо барих мэдээлэл:

- Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, 14210, Энхтайваны өргөн чөлөө 19 хаягт орших Худалдаа, хөгжлийн банкны төв байр
- 11 328227
- boardoffice@tdbm.mn
- Ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд.

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР

№		Агуулга	Хугацаа
1		Хурлын ирцийг бүртгэх	08:30-08:55
2		Хурлын үйл ажиллагааг эхлүүлэх	09:00-09:02
3		Хурлын ирц танилцуулах	09:00-09:05
4		Хурлыг нээх	09:05-09:15
5		Хэлэлцэх асуудлуудын жагсаалтыг танилцуулах	
6		Хуралд танилцуулах асуудал	
	1	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны үйл ажилллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлан	09:15-09:40
	2	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт	
	3	Ногдол ашиг хуваариалах тухайн ТУЗ-ийн шийдвэр	
7		Хурлаар хэлэлцүүлэх асуудал	
	1	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай	09:40-09:55
	2	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах	
	3	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай	
8		Танилцуулга болон хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт, хариулт	09:55-10:05

9	Тогтоолын төслийн танилцуулга		
	1	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай	10:05-10:15
	2	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай	
	3	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай	
10	Санал хураалт		10:15-10:25
11	Завсарлага /Санал тооллого/		10:25-10:40
12	Санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулах		10:40-10:45
13	Хурлын хаалт		10:45-10:50

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

TDB
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

TRADE AND DEVELOPMENT BANK OF MONGOLIA
REPRESENTATIVE GOVERNING BOARD RESOLUTION

2025 оны 03 сарын 13 өдөр Дугаар 12 Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10 дахь хэсэг; 60 дугаар зүйл, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4, 65.5, 65.6 дахь хэсэг; 67 дугаар зүйл, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.4 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам болон "Худалдаа, хөгжлийн банк" ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.2 дахь заалт, 7.4, 7.7, 7.10, 7.11 дэх хэсэг; 8 дугаар зүйлийн 8.11.6 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 09 цаг 00 минутад мэдээллийн технологийн шийдэл (investor.tdbm.mn)-г ашиглан зайнаас буюу цахим хэлбэрээр хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

   2.1. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
   2.2. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай;
   2.3. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Зохион байгуулах комиссыг энэхүү тогтоолын Хавсралт 1-т заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлийг 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т даалгасугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Рандолф Коппаг томилсугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг энэхүү тогтоолын Хавсралт 3-ийн дагуу баталж, уг зарыг Монголын хөрөнгийн бирж, Худалдаа, хөгжлийн банкны цахим хуудсаар болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн дотор олон нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2025 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин олон нийтэд мэдээлэхийг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т үүрэг болгосугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацааг энэхүү тогтоолын Хавсралт 4-ийн дагуу баталж, танилцах боломж нөхцөлөөр хангахыг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т даалгасугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, шийдвэрийн төсөл, саналын хуудас болон тэдгээртэй холбоотой баримт бичгийг 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн дотор Үнэт цаасны компаниудад хэвлэмэл болон цахим байдлаар хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т үүрэг болгосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2025 оны 4 дүгээр сарын 7-ний өдрөөр тогтоосугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэлийн өдроос хойш ажлын 3 хоногийн дотор Монголбанканд хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т даалгасугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудасны загварыг энэхүү тогтоолын Хавсралт 5-ын дагуу баталсугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг энэхүү тогтоолын Хавсралт 2-т заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд урьдчилан санал хүргүүлж буй Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг 2025 оны 4 дугаар сарын 16-ны өдроос 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 17:00 цаг хүртэл цахим хэлбэрээр болон Худалдаа, хөгжлийн банкны тов байран дээр цаасан хэлбэрээр хүлээн авах, Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжид заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын хүлээсэн үүргүүдийг хэрэгжүүлэхийг Тооллогын комисс (Ч.Лхагвасүрэн)-т үүрэг болгосугай.

14. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Н.Нямсүрэн)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА **РАНДОЛФ КОППА**

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК
TRADE AND DEVELOPMENT BANK JSC

ТООЛЛОГЫН КОМИСС ТОМИЛОХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар
сарын 13-ны өдрийн 12 тоот тогтоолын
Хавсралт 2

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисс

Тооллогын комиссын дарга:

Ч.Лхагвасүрэн	Дотоод аудитын газрын захирал;

Тооллогын комиссын гишүүд:

Л.Анхбаяр	Эрх зүйн бодлогын хэлтсийн захирал;
Б.Энхжаргал	Тусгай аудитын хэлтсийн ахлах аудитор;
Х.Оюутсэцэн	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын албаны хуульч.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, ТАНИЛЦАХ ЖУРАМ

1. Хувьцаа эзэмшигч нь дараах баримттай танилцаж болно.

- Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
- 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын байгууллагын дүгнэлт;
- Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоол;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах "Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай" тогтоолын төсөл;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах "Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай" тогтоолын төсөл;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах "Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай" тогтоолын төсөл;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид дараах арга, хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн танилцаж болно. Үүнд:

- Худалдаа, хөгжлийн банкны investor.tdbm.mn цахим хаягт хандан танилцах;
- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандан танилцах;
- Худалдаа, хөгжлийн банкны төв байранд ажлын өдрүүдийн 10:00-17:00 цагийн хооронд Хурал зохион байгуулах комисст хандан танилцах.

Хурлын талаарх мэдээллийг хурал зохион байгуулах комиссын 11-328227 утас болон boardoffice@tdbm.mn цахим хаягаар ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд холбогдож авна уу.

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХАМТДАА

Банкны лого нь мөнгөний нэгж болох зоосны хэлбэрт суурилсан бөгөөд зоосны голд дүрслэгдсэн мөнгөний авдарт тасралтгүй эргэлдэх эргэлтээр дөрвөн зүг найман зовхисоос мөнгө, эд баялаг хуримтлагдан арвижиж, элбэг дэлбэг байхын бэлгэдэлтэй.

АЛСЫН ХАРАА

Хөгжиж буй Монголын дэвшил бүхнийг манлайлагч банк байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид харилцагчдадаа хүсэл, тэмүүлэлдээ хүрэхэд нь зориулж, хүлээлтээс нь давсан санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологиор хүргэнэ.

УРИА

ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА

Банкны ажилтнууд, харилцагчид, хөрөнгө оруулагчид зэрэг хүн бүхнийг хөгжил дэвшлийн зүгт хамт алхахыг уриалан дуудах, нэгтгэх, зоригжуулах утгатай.

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХАМТДАА

Тогтвортой хөгжлийн тодорхойлолт болох ирээдүй хойч үеийн хэрэгцээг бууруулахгүйгээр дэлхийн өнөөгийн хүн амын хэрэгцээг хангах цогц үйл явцыг банк, харилцагч, түнш болон улс орон хамтдаа дэмжиж, нэг зорилгын дор нэгдэж ажиллахыг уриалсан утгатай.

ҮНЭТ ЗҮЙЛС

Бидний харилцагч	Үнэлэмжтэй	Төгс төгөлдөр	Эгнэгт нэлттэй	Эвсэг баг	Гүйцэтгэл төгс	Чин хүндлэл

БҮТЭЭГЧ
CREATOR

Customer centric	Recognition	Excellence	Accessible	Teamwork	Outperforming	Respect

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Худалдаа, хөгжлийн банк ХК (цаашид “ХХБ” эсхүл “Банк” гэх) нь Компанийн засаглалын чиглэлээрх бодлого, дүрэм, журам, зааврууд ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон засаглалын үнэлгээг оновчтой, бодитоор гаргаж, хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд үнэ цэнэ бүтээхэд дэмжлэг үзүүлэх, дотоодын төдийгүй олон улсын сайн туршлагыг нутагшуулан ТУЗ болон банкны бүхий л нэгжид хүрч, банкны стратеги төлөвлөгөө, байгууллагын бүтэц, бодлогыг тодорхойлон, оролцогч талуудын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдол өгч ажилладаг.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт зааснаар Банкны эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг ТУЗ-ийн шийдвэрээр санхүүгийн жил дуусснаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулдаг.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Гаргасан хувьцааны төрөл: Энгийн

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Банкны эрх барих дээд нэгжийн хувьд Төлөөлөн удирдах зөвлөл нь жендерийн зохисттой харьцааг эрхэмлэн үзэж, шийдвэр гаргах түвшинд оролцооны эрх тэгш байдлыг хангахыг зорьж Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”, Банкны дүрэм болон холбогдох бусад эрх зүйн актын хүрээнд Банканд тулгарч буй асуудлуудыг бодлогын хэмжээнд шийдвэрлэх, үйл ажиллагааг дэмжих, гүйцэтгэх удирдлагыг сонгож, чиглүүлэх үүргийнхээ дагуу банкны стратеги зорилго, зорилтыг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөмж, чиглэлээр ханган ажилладаг.

УДИРДЛАГЫН БАГ

ХХБ-ны удирдлагын баг нь банк, санхүүгийн чадварлаг менежерүүдээс бүрддэг ба компанийн засаглалын зохистой бүтэц, олон жилийн туршлага нь удирдлагын багийн амжилттай ажиллах суурь нь болдог. Мөн банкны урт удаан хугацааны ашигт ажиллагааг хангах, улмаар хувь нийлүүлэгчдийн үнэ цэнийг өсгөх боломжийг олгодог.

АЖИЛТНУУД

ХХБ-ны амжилтын үндэс нь эрч хүчтэй, чадварлаг ажилтнууд бөгөөд тэднийг шударгаар урамшуулах, дэмжих, албан тушаал дэвшүүлэх хөгжлийн тогтолцоог сайжруулснаар харилцагчиддаа банкны шилдэг үйлчилгээг үзүүлж чаддаг.

БИД

ХХБ нь хууль, ёс зүйн хариуцлагын хүрээнд нийцсэн ажиллах орчныг бүрдүүлэхийг үргэлж эрмэлзсээр ирсэн. Харилцагч, бизнесийн түншүүд болон нийгэмдээ банкны шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэн, хувь нийлүүлэгчид болон харилцагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ шударга байх зарчимтай.

ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

АУДИТЫН ХОРОО

Аудитын хороо нь Банкны засаглал, хууль тогтоомжийн хэрэгжилт, ёс зүйн хэм хэмжээ, санхүүгийн тайлагналт, дотоод хяналтын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудитын үйл ажиллагаанд системтэйгээр дүгнэлт өгөх, банкны хувьцаа эзэмшигчид, ТУЗ болон бусад оролцогч талуудад үнэн зөв бодит мэдээллийг хүргэх замаар байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүх түвшинд сайн засаглалын тогтолцоог бэхжүүлэх зорилготой, ТУЗ-ийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч хороо юм. Аудитын хороо нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр (үүнээс хараат бус 2 гишүүнтэй) Аудитын хорооны дүрэмд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.



ДОТООД АУДИТ

Дотоод аудит нь байгууллагын засаглалын чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагыг хараат бус, эрсдэлд суурилсан, бодитой баталгаажуулалт, зөвлөгөө, гүн ойлголт болон алсын хараагаар хангах замаар байгууллагын үнэ цэнийг бий болгох, хамгаалах, мөн тогтвортой байлгах чадварыг бэхжүүлдэг. ХХБ-ны дотоод аудитын үйл ажиллагааг ТУЗ-ийн харьяа Аудитын хороо, Дотоод аудитын газар хариуцан ажиллаж байна.

Дотоод аудитын газар нь чиг үүргийн болон захиргааны асуудлаар ТУЗ, Аудитын хороонд харьяалагдаж, гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд ТУЗ, Аудитын хороонд ажлаа тайлагнаж, гүйцэтгэх удирдлагад аудитын үр дүнг мэдээлэх зарчмаар ажилладаг. Аудитын хороо нь дотоод аудитын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хэлэлцэн, ДАГ-ын үйл ажиллагаа, хараат бус байдалд хяналт тавихын зэрэгцээ дотоод аудитын үйл ажиллагааг дэмжин ажилладаг.

ДОТООТ АУДИТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Дотоод аудитын газар нь Олон улсын дотоод аудиторуудын институтийн гаргасан Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ, олон улсын сайн туршлагыг үйл ажиллагаандаа удирдамж, жишиг болгон, банкны засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын үр дүнтэй байдалд хараат бус, эрсдэлд суурилсан, бодитой баталгаажуулалт хийн, үнэлж дүгнэн, сайжруулах, банкны зорилгодоо хүрэх байдалд хувь нэмэр оруулан ажиллаж байна.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Худалдаа, хөгжлийн банкны Эрсдэлийн удирдлагын бодлогын зорилго нь банкны стратеги зорилтыг хэрэгжүүлэх, тогтвортой хөгжлийг хангахад туслалцаа үзүүлэх ба банкны үйл ажиллагаанд гарах алдагдал, эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах замаар банкны ашигт ажиллагааг дэмжихэд чиглэдэг. Банк нь эрсдэлийн удирдлагын тогтолцоондоо олон талт зарчмуудыг мөрдлөг болгодог.

Байгууллагын эрсдэлийн удирдлага ("Enterprise Risk Management" цаашид ERM гэх)-ын зохистой засаглалыг бизнесийн бүх үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг бөгөөд ERM нь эрсдэлийн орчныг тасралтгүй хянах, сайжруулах боломжийг бий болгож, эрсдэлийн талаарх ойлголт, мэдлэг, найдвартай ажиллагаа, стратеги шийдвэр гаргах зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг. Банкны хувь нийлүүлэгчдийн хурлаас банкны стратегийн шийдвэрүүдийг гаргах бөгөөд уг стратегид тулгуурлан банкны эрсдэлийн засаглалыг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэх үүрэг бүхий хамгийн дээд нэгж нь "Төлөөлөн удирдах зөвлөл" (ТУЗ) болон түүний дэргэдэх "Эрсдэлийн удирдлагын хороо" (ЭУХ) юм.

САНХҮҮ, БҮРТГЭЛИЙН ТОГТОЛЦОО

Худалдаа, хөгжлийн банк нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Банкны тухай хууль, НББОУСтандарт, СТОУСтандарт, ААНОАТатварын хууль болон татварын бусад хууль, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан Банкны нягтлан бодох бүртгэлийн багц материал болон санхүүгийн тайлангийн талаар Монгол улсын Засгийн газар, Сангийн яам, Монголбанкнаас гаргаж мөрдүүлсэн бусад заавар, журам, Худалдаа хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын тушаалаар батлан мөрдүүлж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон бусад дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгодог.

Банкны нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлан гаргалтыг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэн тайлагнаснаар хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл, банкны газар, нэгж, бүх шатны ажилтнуудыг тоон мэдээллээр түргэн, шуурхай хангаж тэдгээрт санхүү, эдийн засгийн оновчтой шийдвэр гаргах, банкны орлого бүрдүүлэлт, зардлын хэмнэлтэд эерэг нөлөө үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж өгдөг.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ИЛ ТОД БАЙДАЛ

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООНЫ ЗАСАГЛАЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 2 сарын 17-ны өдрийн 9 тоот тогтоолоор

Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр, Худалдаа, хөгжлийн банкнаас бусад оролцлогч талуудтай харилцах, хамтран ажиллахад баримтлах бодлогыг баталсан бөгөөд тус бодлогод харилцагч талуудтай банкнаас харилцахдаа тэдгээрийн хэрэгцээ шаардлага, ашиг сонирхлыг тодорхойлж хамтран ажиллах, оролцоог хүлээн зөвшөөрөх, эрх ашгийг хүндэтгэх, хамтран ажиллах харилцааг хууль эрх зүйн хүрээнд зохицуулах арга хэмжээг нарийвчлан тусгаж, банкны бүхий л түвшинд үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах боломжтой болсоноор засаглалын бодлогыг илүү ил тод болгосон.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ТУЗ нь үйл ажиллагаагаа хуулиар олгогдсон эрхийн хүрээнд хэрэгжүүлж банкны стратеги, төлөвлөгөө, байгууллагын бүтэц, бодлогыг тодорхойлох, төсөв төлөвлөгөөг батлан гүйцэтгэлийг хянах болон гүйцэтгэх удирдлагыг зөвлөмж, чиглэлээр хангах, ХХБ-ны үйл ажиллагааг удирдан чиглүүлж, оролцогч талуудын үнэ цэнийг нэмэгдүүлэхийг зорьж ажилладаг.

ХХБ нь ТУЗ-ийг олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, ашиг сонирхлын зөрчил, хараат бус байдал, хүйсийн тэнцвэр зэргийг зохистойгоор хангасан гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр бүтээлч, үр дүнтэй бүтэцтэй байлгахыг зорьдог ба Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгон томилно.

ТУЗ-ИЙН ДАРГА

Рандолф КОППА

ГИШҮҮД

Должин ЭРДЭНЭБИЛЭГ
Дамбийжав ХҮРЭЛБААТАР
Дагмид ЯНЖМАА
Авгаан ЭНХМЭНД
Дэмчигжав ОТГОНБИЛЭГ

ХАРААТ БУС ГИШҮҮД

Жалбаа БОЛОРМАА
Жамсрандорж ДЭЛГЭРСАЙХАН
Загдхүү НАРАНТУЯА /2024.11.04 хүртэл/

Хорооны нэр	Нийт хурлын тоо	Хэлэлцсэн асуудлын тоо	Баталсан тогтоол, шийдвэр	Дундаж ирц
Төлөөлөн удирдах зөвлөл	25	85	76	77.8%
Аулитын хороо	4	9	9	100%
Эрсдэлийн удирдлагын хороо	6	12	12	100%
Цалин, урашууллын болон нэр дэвшүүлэх хороо	11	20	20	100%
Тогтвортой хөгжлийн хороо	2	9	9	100%

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРОО

АУДИТЫН ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь Банкны засаглал, хууль тогтоомжийн хэрэгжилт, ёс зүйн хэм хэмжээ, санхүүгийн тайлагналт, дотоод хяналтын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудитын үйл ажиллагаанд системтэйгээр дүгнэлт өгөх, банкны хувьцаа эзэмшигчид, ТУЗ болон бусад оролцогч талуудад үнэн зөв бодит мэдээллийг хүргэх замаар байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүх түвшинд сайн засаглалын тогтолцоог бэхжүүлэх зорилготой. Дотоод аудитын хараат бус, бие даасан байдлыг хангах үүднээс Дотоод аудитын газар (цаашид "ДАГ" гэх) нь ТУЗ-ийн шууд удирдлага дор ажилладаг ба ТУЗ-ийн дэргэдэх хараат бус гишүүнээр даргалуулсан Аудитын хороонд ажлаа тайлагнадаг нь хяналтын нэгжийн үүргийг хараат бус, бие даасан байдлаар хэрэгжүүлэх боломжийг хангадаг.

Аудитын хороо нь дараах бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Үүнд:

- Хорооны дарга - ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Дэлгэрсайхан,
- Хорооны гишүүн - ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Болормаа,
- Хорооны гишүүн - ТУЗ-ийн гишүүн Д.Отгонбилэг.

Аудитын хорооны бүрэлдэхүүнд тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй.
Хорооны нарийн бичгээр ЕАХ-ийн захирал Л.Одмаа ажиллаж байна.

ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН БОЛОН НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо (цаашид “ЦУНДХ” гэх) нь ХХБ-ны ТУЗ-ийн хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, ашигтайгаар хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх эрх, үүрэг бүхий 3 гишүүний бүрэлдэхүүнтэй, 1/3 буюу 2 гишүүн нь хараат бус гишүүн байна. Тус хороо нь ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүнд эргэн хяналт хийх, гишүүдийг сонгон шалгаруулах, үнэлэх, Гүйцэтгэх удирдлага болон удирдлагын түвшний захирлуудыг нэр дэвшүүлэх, ТУЗ-ийн үйл ажиллагааг дүгнэж тайлагнах, тэдгээрийн цалин хөлс урамшууллын хэмжээ, бодлогыг тодорхойлох, банкны бүтэц, зохион байгуулалт, засаглалыг хөгжүүлэх чиглэл өгөх зэрэг эрх үүрэгтэй хороо болно.

ТУЗ-ийн 2023 оны 8-р сарын 10-ны өдрийн 57 тоот тогтоолоор Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсон. Үүнд:

- Хорооны дарга - ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Болормаа,
- Хорооны гишүүн - ТУЗ-ийн хараат бус гишүүн З.Нарантуяа (2024 оны 11 дүгээр сарын 4-ны өдрийг хүртэл),
- Хорооны гишүүн - ТУЗ-ийн гишүүн Д.Янжмаа.

Хорооны нарийн бичгээр Хүний нөөцийн газрын захирал Б.Цэрэндолгор ажиллаж байна.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО

Банкны тухай хуулийн дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүнээр даргалуулсан, ТУЗ-ийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль журам, зохицуулагч болон олон улсын байгууллагууд, Базелийн хорооноос тогтоосон зөвлөмж, стандарт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо, бодлого зэргийн хэрэгжилтийг хянах, чиглэл өгөхөд дэмжлэг үзүүлэх чиглэлийн хороо юм. Үйл ажиллагааны өргөн цар хүрээг хамарч хараат бус байдлаар эрсдэлээс хамгаалах, зах зээл, үйл ажиллагааны эрсдэл болон комплайнсын хэрэгжилтэнд баталгаажуулалт хийж, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж өгч ажилладаг.

ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 57 тоот тогтоолоор Эрсдэлийн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсон. Үүнд:

- Хорооны дарга - ТУЗ-ийн хараат бус гишүүн З.Нарантуяа (2024 оны 11 дүгээр сарын 4-ны өдрийг хүртэл),
- Хорооны гишүүн – ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Дэлгэрсайхан,
- Хорооны гишүүн – ТУЗ-ийн гишүүн Рандолф Коппа.

Хорооны нарийн бичгээр Эрсдэлийн удирдлага, бодлого зохицуулалтын газрын захирал Д.Дэлгэрмаа ажиллаж байна.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХОРОО

Тогтвортой хөгжлийн бодлогоор банкны засаглал, стратеги, зорилго, зорилтыг тодорхойлох, дотоодын болон олон улсын сайн туршлагыг өөрийн төдийгүй оролцогч талуудын үйл ажиллагаанд нутагшуулах, ногоон болон тогтвортой бизнесийн зарчмууд, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор байгуулагдсан болно. Байгаль орчин, нийгэм, засаглалын удирдлага, бодлогыг хэрэгжүүлэх замаар банкныхаа үйл ажиллагааны бүхий л түвшинд төдийгүй Монгол Улсдаа үлгэрлэн манлайлах зарчмыг баримтлан ажиллах ба нийт Худалдаа, хөгжлийн банкны ажилтнууд, харилцагчид, түншүүд болон бусад оролцогч талуудтай хамтдаа тогтвортой хөгжлийг цогцлооход нягт уялдаа холбоотой ажиллахад тус хорооны үндсэн зорилго оршино.

ТУЗ-ийн 2024 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 34 тоот тогтоолоор
Тогтвортой хөгжлийн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсон. Үүнд:

- Хорооны дарга - ТУЗ-ийн дарга Рандолф Коппа,
- Хорооны гишүүн - Олон улсын бизнес хөгжлийг хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч Н.Сэргэлэн,
- Хорооны гишүүн - ТУЗ-ын дэргэдэх Ажлын албаны Олон улсын хамтын ажиллагаа болон Байгаль орчин, нийгэм, засаглалыг хариуцсан зөвлөх Г.Чимидбалдир,
- Хорооны гишүүн - Тогтвортой хөгжлийн зөвлөх П.Халиун.

Нарийн бичгээр Гадаад эх үүсвэрийн удирдлага, хяналтын хэлтсийн Харилцааны ахлах менежер Г.Онон ажиллаж байна.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО, ЖУРАМ

Худалдаа, хөгжлийн банк нь хуулийн этгээдийн хэлбэрээ хувьцаат компани болгон өөрчилсөн бөгөөд үүний дагуу зохицуулагч байгууллагуудаас баталсан дагаж мөрдөх журам, зааврууд хэрэгжилтийг хангах, хэрэгжүүлэх, банкны дотоод заавар журамдаа тусгах, өөрчлөх, нийцүүлэх үйл ажиллагааг тогтмол хийн ажиллаж байна.

Засаглалын бодлого, журмыг тогтоох, батлах, шинэчлэн батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;

- “Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам”;
- “Аудитын хорооны дүрэм”;
- “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”;
- “ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх журам”.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТӨД УУЛ УУРХАЙ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД ГОЛЛОН НӨЛӨӨЛЛӨӨ

ДНБ 2024 онд 4.9 хувиар өссөний -3.6 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбар, 1.4 нэгж хувийг уул уурхай, олборлолтын салбар, 0.3 нэгж хувийг үйлдвэрлэл, барилгын салбар, 4.8 нэгж хувийг үйлчилгээний салбар, 2.0 нэгж хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар бүрдүүлсэн байна. Уул уурхайн олборлолт, үйлчилгээний салбарын идэвхжил, үүнийг дагасан татварын өндөр орлого өсөлтийг голлон дэмжлээ. Уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2024 онд 4.3 их наяд төгрөг болж, өмнөх оноос 419.2 (10.8%) тэрбум төгрөгөөр өслөө. Үйлчилгээний салбарын нийт нэмэгдэл өртөг (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2024 онд 16.3 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.5 (9.8%) их наяд төгрөгөөр өслөө. Үүнд тээвэр, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын нэмэгдэл өртөг өссөн нь голлон нөлөөлжээ. Харин цаг агаарын тааламжгүй нөхцөл байдлаас шалтгаалсан хөдөө аж ахуйн салбарын агшилт эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлсэн хэвээр байна. Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2024 онд 2.8 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.1 (28.7%) их наяд төгрөгөөр буурсан нь ДНБ-ий өөрчлөлтөд 3.6 нэгж хувиар сөрөг нөлөө үзүүлсэн байна.



МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ НЭГ ШАТ АХИЖ "B+", "B2, ТОГТВОРТОЙ" БОЛЛОО

Олон улсын тэргүүлэх зээлжих зэрэглэл тогтоогч агентлагуудаас Монгол улсын зээлжих зэрэглэлийг ахиулсан нь 2024 оны онцлох үйл явдал боллоо. Олон улсын "Fitch" агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "B+, тогтвортой" болгож, "S&P Global" агентлаг "B+, эерэг" болгон ахиулсан бол Moody's агентлаг зээлжих зэрэглэлийг "B2", хэтийн төлөвийг "тогтвортой" зэрэглэлд тус тус ахиулсан нь сүүлийн 10 жилийн дээд түвшин болов.

B+ B2 ТОГТВОРТОЙ

Монгол Улс гадаад өрийн дарамтаа бууруулж, санхүү, төсвийн сахилга батыг сахихаас гадна валютын нөөцөө тогтмол нэмэгдүүлж, улс төрийн тогтвортой байдлыг бүрдүүлсэн зэрэг нь үүнд нөлөөлжээ. Зээлжих зэрэглэл дээшилснээр Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулагчдын итгэх итгэл сайжирч, олон улсын санхүүгийн зах зээлээс илүү таатай нөхцөлөөр санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэх давуу талтай юм.

Жилийн инфляц



Монгол Улс 2024 онд нийт 83.7 сая тонн нүүрс экспортолсон нь манай улсын түүхэнд анх удаа нүүрсний экспорт 80 сая тонн давсан үзүүлэлт юм. Нэг тонн нүүрсийг дунджаар 103.9 ам.долларoор нийлүүлж, 8.7 тэрбум ам.долларын орлогыг олжээ. 2023 онтой харьцуулахад нүүрсний экспортын биет хэмжээ 20.3 хувиар өссөн хэдий ч нийт үнийн дүнгийн хувьд 2.3 хувиар буурсан байна.
Харин уул уурхайн гаралтай гол нэрийн зургаан эрдэс бүтээгдэхүүний экспортын нийт дүн 13.2 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос таван хувийн өсөлт үзүүллээ.

9%

ИНФЛЯЦ 2024 ОНЫ ЭЦЭСТ МОНГОЛБАНКНЫ ЗОРИЛТОТ ТҮВШНЭЭС ДАВЖ ЭРЧИМЖИВ:

Оны турш төв банкны зорилтот интервалд хадгалагдаж байсан инфляц алгуур эрчимжин, оны эцэст жилийн 9.0 хувьд хүрч зорилтот түвшнээс 1 нэгж хувиар давав.

11.8%

ГАДААД ВАЛЮТЫН АЛБАН НӨӨЦ ТҮҮХЭН ДЭЭД ХЭМЖЭЭНД ХҮРЛЭЭ:

2024 оны эцэст Монгол Улсын гадаад валютын албан нөөц 5.5 тэрбум ам.доллар давж, өмнөх оноос 11.8 хувиар өслөө. 2024 онд төлбөрийн тэнцэл ашигтай гарсан төдийгүй Монгол Улсын зээлжих зэрэглэл ахиж, банкнууд гадаад зах зээлээс бонд босгосон зэрэг нь валютын нөөц нэмэгдэхэд нөлөөлжээ.

БАНКНЫ СЕКТОР

Монгол улсын хувьд арилжааны банкнууд санхүүгийн зуучлалын үүргийг голчлон гүйцэтгэж, санхүүгийн байгууллагын хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлж, санхүүгийн системд чухал байр суурийг эзэлж байна. Банкны секторын тогтвортой байдал нь санхүүгийн системийн эрсдэл даах чадвар, ерөнхий зураглалыг харуулдаг чухал үзүүлэлт юм. 2024 онд банкны секторын нийт активын хэмжээ жилийн 25.1 хувиар үргэлжлэн өсөж 71.4 их наяд төгрөгт хүрлээ.

ЗЭЭЛ

Банкны секторын нийт цэвэр зээл 2024 оны эцсийн байдлаар нийт активын 49.3 хувийг бүрдүүлж байна. Өнгөрсөн оны эцэстэй харьцуулахад нийт зээл 35.5 хувиар буюу 9.6 их наяд төгрөгөөр өсөж 36.78 их наяд төгрөгт хүрлээ. Нийт зээлийн өсөлтийн 15.4 нэгж хувь буюу хамгийн өндөр хувийг иргэдийн зээлийн өсөлт бүрдүүлж байгаа бөгөөд төсвийн тодотголоор цалин, тэтгэврийг үе шаттайгаар нэмэгдүүлснээр өрхийн нэрлэсэн орлого өсөж, улмаар өрхүүдийн өр-орлогын харьцааны хязгаарлалтын хүрээнд авах боломжит зээлийн дүн нэмэгдсэн нь хэрэглээний зээлийн өсөлт эрчимжихэд нөлөөлжээ. Тайлант оны эцсийн байдлаар банкны секторын чанаргүй зээлийн түвшин 5.08 хувь болж сүүлийн 10 жилийн хамгийн доод түвшинд хүрч сайжирлаа.

ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

Банкны секторын харилцагчаас татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламж 2024 оны эцсийн байдлаар нийт пассивын 62%-ийг бүрдүүлж байна. Харилцах, хадгаламж жилийн 13.3 хувиар өсөж 39.6 их наяд төгрөг болжээ. Тодруулбал, хадгаламж өмнөх оны эцсээс 21.2 хувиар өсөж 25.6 их наяд төгрөгт, харилцах өмнөх оны эцсээс 1.3 хувиар өсөж 14.0 их наяд төгрөгт хүрсэн байна.

АШИГТ АЖИЛЛАГАА

2024 онд банкны салбар өмнөх жилийн ашгийг 32.9 хувиар нэмэгдүүлж 1.72 их наяд төгрөгийн ашигтай ажиллаа. Банкнууд ашигт ажиллагаа сайжирч, өөрийн хөрөнгө нэмэгдэж байгаа нь банкны системийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж байна.





2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

BNY MELLON

Монгол Улс 2019 онд ФАТФ-ын саарал жагсаалтад орсноор Монголын арилжааны банкнууд дэлхийн ам.долларын төлбөр тооцооны системээс хасагдсан. Харин ХХБ АНУ-ын клирингийн ТОП банк болох **BANK OF NEW YORK MELLON**-тай хамтран ажиллаж, Монгол Улсыг дэлхийн ам долларын төлбөрийн системд эргэн холболоо.

25%

Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Гүйцэтгэх удирдлагаас бусад ажилтнуудын бүтээмжийн цалинг 25 хүртэлх хувиар дахин нэмэгдүүллээ.

TRADE FINANCE FORUM 2024 | RESTORE & UNLOCK

ХХБ-аас уламжлал болгон зохион байгуулдаг "Trade Finance Forum 2024" арга хэмжээ "Restore & Unlock" сэдэвтэйгээр боллоо. Олон улсын худалдаа, түүний санхүүжилтийн сүүлийн үеийн чиг хандлага, хөгжлийг хэлэлцэж, бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ дамжуулан харилцагчдынхаа өрсөлдөх чадварыг нэмэгдүүллээ.

Хуримтлалтай Монгол аяны урамшуулын эрх үржигддэг болж, 5 дахь жилдээ амжилттай үргэлжилж, 300 харилцагчдаа мөнгөн урамшуулал олгож, 2 харилцагчид СУПЕР УРАМШУУЛЛЫН ТАУН ХАУС, БАЙРАА гардуулж өглөө.

Apple Pay

Дэлхийн төлбөр тооцооны шилдэг шийдэл ApplePay үйлчилгээг Монгол Улсад анхлан нэвтрүүллээ.

A1 ARCHITECTS

Монгол Улсынхаа Үндэсний компани A1+ Partners-тай хамтран салбар тооцооны төвүүдийнхээ дотор интерьер тохижилтыг өөрчилж эхэллээ.

PCI Security Standards Council

Төлбөрийн картын аюулгүй байдлын олон улсын PCI DSS 4.0 стандартыг амжилттай хамгаалан 8 дахь жилдээ батламжаа гардан авлаа. Энэ нь аюулгүй байдлын бүхий л шаардлагуудыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж, харилцагчийн карт болон хувийн мэдээллийн нууцлалыг задруулах эрсдэлээс бүрэн хамгаалан ажилладгаа дахин баталсан юм.

2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Худалдаа, хөгжлийн банк болон Ханбогдын Хөгжлийн Хурдасгуур Оюу Толгойн сан нар харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа. Санамж бичиг байгуулснаар хоёр тал "Монгол Улс дахь бүс нутгийн ногоон хөгжлийг дэмжих бэлэн байдлын төсөл"-ийн хүрээнд хамтран ажиллах юм.

Монгол Улсад анх удаа олон улсын хамгийн том боловсролын арга хэмжээ болох STEAMEX 2024 зохион байгуулагдлаа. Энэхүү төсөлд хамрагдах хүсэлтэй 21 аймгийн 100 багш-ийн төлбөрийг ХХБ төлж дэмжин ажиллалаа

Худалдаа Хөгжлийн Банк Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгтэй хамтран "SFME" төслийг хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурлаа. Монгол улсын тогтвортой хөгжил болон ногоон ирээдүйд чиглэсэн ЖДБ-ийг дэмжих, ЖДБ эрхлэгчдэд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой юм.

Худалдаа Хөгжлийн банк урт хугацааны стратеги зорилгынхоо хүрээнд Монгол Улсын эдийн засгийн хөдөлгөгч хүч болсон жижиг дунд бизнесүүдийг идэвхтэй дэмжин ажилладаг. Энэхүү бодлогынхоо хүрээнд Дижитал кредит ХХК-тай хамтран ажиллахаар боллоо.

Худалдаа, Хөгжлийн Банк нь АНУ-ын засгийн газрын агентлаг, Олон Улсын Хөгжлийн Санхүүжилтийн Корпорац буюу DFC-тэй (U.S. International Development Finance Corporation) байгуулсан урт хугацааны санхүүжилтийн гэрээг үзэглэх ёслол амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү гэрээг үзэглэснээр Монгол улсын банк санхүүгийн байгууллага нь АНУ-ын ХСК-аас шууд санхүүжилт босгосон анхны тохиолдол болж байна. Тус санхүүжилтээр ХХБ нь Монгол Улс дахь бичил ба жижиг, дунд үйлдвэрлэл, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээл, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд зарцуулах замаар МУ-ын тогтвортой санхүүжилт, тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх том алхам болох юм.

EuroChamber Mongolia-с зохион байгуулсан "The EU Global Gateway Strategy and Financing Opportunities" арга хэмжээг Худалдаа Хөгжлийн Банк дэмжин ажиллаа. Уулзалтын үеэр "Global Gateway Strategy" төслийн хүрээн дэх секторуудын хөрөнгө оруулалтыг дэмжих, түүний ил тод байдал, эрх тэгш түншлэл, ногоон, цэвэр аюулгүй байдлыг хангасан дэд бүтцүүдийг нэмэгдүүлэхээр хэлэлцэв.

Жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүддээ зориулсан BE LADY форумыг анх удаа амжилттай зохион байгуулаа.

2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

WORLD ECONOMIC FORUM

Дэлхийн Эдийн Засгийн Форумын "Шинэ Манлайлагчдын 15 дахь удаагийн чуулга уулзалт" БНХАУ-ын Далянь хотноо боллоо. Зуны Давос форумд ХХБ-ыг төлөөлж ТУЗ-ийн дарга Рандолф Коппа болон ГЗО Н.Сэргэлэн нар оролцлоо.

ちばぎん

ХХБ Япон улсын Чиба банктай хамтран харилцагч байгууллагуудын бизнес уулзалт зохион байгуулаа. Гол зорилго нь МУ-ын эдийн засгийн нөхцөл байдал болон бизнесийн орчныг таниулан сурталчлах, хоёр улсын төрийн байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагуудын хөрөнгө оруулалт, бизнесийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд оршино.

KOREA TOURISM ORGANIZATION

ХХБ болон Korea Tourism Organization нь "Хамтын ажиллагааны санамж бичиг"-т гарын үсэг зурлаа. Ийнхүү хоёр улсын аялал жуулчлал, эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, ХХБ-ны карттай харилцагч нарт БНСУ-ын аялал жуулчлалын болон эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудад хөнгөлөлт урамшуулалтай үйлчүүлэх зэрэг олон талын хамтын ажиллагаа эхэллээ.

Үндэсний соёл амралтын хүрээлэн, Рио парк хоёрын дунд орших талбайд Happy Park-г шинээр бүтээлээ. Өдөр бүр, долоо хоног бүр өөр өөр хэлэлцүүлэг, эвент арга хэмжээ, хамтлаг дуучдын тоглолттой энэхүү чөлөөт паркаа Бритто виза карттай харилцагч нартаа зориуллаа.

MONGOLIAN MINING WEEK 2024 | MINEPRO 2024

Уул уурхайн долоо хоног буюу Minig Week & MinePro 2024 олон улсын үзэсгэлэн, чуулга уулзалт 4 өдрийн турш зохион байгуулагдлаа. Энэхүү арга хэмжээний ивээн тэтгэгчээр Дэлхийн Уур амьсгалын ногоон сангийн үндэсний итгэмжлэгдсэн байгууллага Худалдаа хөгжлийн банк ажиллалаа.

Франц-Монгол хоёр орны хооронд бизнес эрхэлдэг бизнес эрхлэгч нартаа зориулсан VIP хүлээн авалт зохион байгуулаа.

bpifrance

ХХБ болон Францын төрийн өмчит хөрөнгө оруулалтын банк болох BPIFrance "Стратегийн хамтын ажиллагааны санамж бичиг"-т гарын үсэг зурлаа. Стратегийн хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд талууд хоёр улсын бизнес, эдийн засаг, худалдааг дэмжих зэрэг олон талын хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр харилцан тохиролцов.

2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

MOODY'S

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоох үнэлгээний байгууллага Moody's агентлаг нь Худалдаа, Хөгжлийн Банкны зээлжих зэрэглэлийг **B3-аас B2 "Тогтвортой"** болгож ахиуллаа.

UN-Day 2024 буюу Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ийн өдөр амжилттай зохион байгуулагдлаа. "Тогтвортой, хүртээмжтэй хөгжлийн төлөө НҮБ болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа" сэдвийн дор зохион байгуулагдсан энэ удаагийн арга хэмжээнд ХХБ-ны Олон Улсын Бизнес хөгжлийг хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч Н.Сэргэлэн оролцлоо.

30+ Ногоон санаачилга ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХАМТДАА

Худалдаа, хөгжлийн банк Монгол Улсад тогтвортой санхүүжилтийн цар хүрээг тэлэх зорилгоор Даян дэлхийн ногоон хөгжлийн институттэй харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа. Уг хамтын ажиллагааны хүрээнд талууд тогтвортой санхүүжилтийг нэмэгдүүлэх, ногоон шилжилтийг эрчимжүүлэх чиглэлд тусгайлан ажиллаж, банкны зүгээс "Тогтвортой санхүүжилтийн хүрээ" баримт бичгийг шинэчлэн боловсруулах юм.

COP29 Baku Azerbaijan

НҮБ-ын суурь конвенцын Талуудын 29 дүгээр бага хурал (COP29) Азербайжан улсын Баку хотноо амжилттай болж өндөрлөө. ХХБ-ны ТУЗ-ийн дарга Р.Коппа нь Байгаль орчин, орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяагаар ахлуулсан багт Монголын Бизнесийн зөвлөлийн төлөөлөөр оролцож, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт татах боломжийг нэмэгдүүлэх салбар хуралдаанд оролцлоо.

sibos

Дэлхийн гадаад төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгч тэргүүлэгч байгууллага болох Thunes болон ХХБ нар БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгуулагдсан SIBOS 2024 арга хэмжээний үеэр хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа. Ингэснээр ХХБ харилцагчдадаа үзүүлж буй гадаад шилжүүлгийн үйлчилгээгээ төрөлжүүлэх алхмаа хийлээ.

sibos BEIJING 21 - 24 Oct 2024

ХХБ-ны хамт олон дэлхийн банк, санхүүгийн арга хэмжээ болох "Sibos-2024" баг хамт олноороо амжилттай оролцож шинэлэг санал санаачилга, стратеги зорилтуудын талаар туршлага солилцлоо.

Монгол дахь Америкийн Худалдааны танхимаас зохион байгуулдаг хамгийн том арга хэмжээ "CSR AWARDS 2024"-н цорын ганц "Diamond" спонсороор ХХБ ажиллалаа.

2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

wiener boerse

Худалдаа Хөгжлийн Банк Монгол Улсаас анх удаа Олон улсын мэргэжлийн хөрөнгө оруулагчдад зориулсан Нийгмийн болон Ногоон бондыг хаалттай хэлбэрээр Австри Улсын Венийн Хөрөнгийн Бирж дээр гаргалаа. Тус бондыг гаргаснаар Дэлхийн ТОП аравт багтдаг Ассет Менежмент Компаниас хөрөнгө оруулалт татсан Монголын анхны хувийн хэвшлийн компани ХХБ болж байна. Мөн хөрөнгө оруулалтын Bloomberg терминал дээр бүртгэлтэй Монголын анхны Ногоон болон Нийгмийн бонд юм.

Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, ToC Холбоо хамтран тогтвортой санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан, салбартаа манлайлагч байгууллагуудыг жил бүр тодруулдаг уламжлалтай. Тус холбооноос 2024 онд жендерийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлуудыг үнэлэн, ХХБ-ыг "Жендерийн Манлай Байгууллага"-аар шалгаруулаа.

UNIQLO

Япон улсын UNIQLO брэндээс албан ёсны худалдан авалт хийж, үйлчилгээний ажилтнуудынхаа дүрэмт хувцсыг өөрчиллөө.

Euromoney сэтгүүл жил бүр дэлхий даяар банк, санхүүгийн салбарынхны ололт амжилтыг үнэлж, шилдгийн шилдгийг шалгаруулдаг шагналын хөтөлбөр болох "Awards for Excellence"-г зохион байгуулдаг билээ. Тэгвэл тус сэтгүүлээс 2024 оны "The Best Bank for Corporates" буюу "Шилдэг Байгууллагын Банк"-аар Худалдаа, хөгжлийн банкыг шалгарууллаа.

Агент банкны үйлчилгээг нэвтрүүлж, банкны биет салбар, нэгж байршдаггүй бүс нутгийн харилцагчдад агентаар дамжуулан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүргэх боломжтой боллоо.

Америк -Монгол хоёр орны хоорондбизнес эрхэлдэг бизнес эрхлэгч нартаа зориулсан VIP хүлээн авалт зохион байгуулаа.

Худалдаа, хөгжлийн банк Нийслэлийн Жижиг, Дунд Үйлдвэрлэл, Үйлчилгээг Дэмжих Төв НӨҮГ, Зээлийн Батлан Даалтын Сантай хамтран Улаанбаатар хотын ЖДҮҮ эрхлэгч нарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэхээр боллоо.

Канад улсын IMAGE X компанитай хамтран харилцагч, олон нийтэд зориулсан мэдээллийн вэбсайтаа шинэчиллээ.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тэрбум төгрөгөөр

Хөрөнгө	2022	2023	2024
Бэлэн мөнгө ба Монголбанкин дахь мөнгөн хөрөнгө	1,756.2	2,308.7	3,094.6
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь мөнгөн хөрөнгө	767.1	1,651.8	1,396.7
Санхүүгийн хөрөнгө оруулалт	1,669.9	1,917.9	2,904.0
Охин болон хараат компани дахь хөрөнгө оруулалт	0.9	5.2	0.2
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	265.4	172.2	88.8
Зээл ба урьдчилгаа	4,137.2	4,933.5	6,179.6
Бусад хөрөнгө	466.0	509.2	555.3
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	80.0	53.3	80.7
Борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгө	24.7	8.3	95.4
Үндсэн хөрөнгө, цэвэр	470.6	568.0	548.5
Ашиглах эрхтэй хөрөнгө	15.4	13.2	9.0
Биет бус хөрөнгө, цэвэр	1.4	25.3	47.6
НИЙТ ХӨРӨНГӨ	9,654.8	12,166.6	15,000.4

Өр төлбөр	2022	2023	2024
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	33.1	318.4	378.9
Буцаан худалдаж авах гэрээгээр борлуулсан үнэт цаас	316.8	51.3	25.7
Харилцагчдын харилцах, хадгаламж	6,207.3	9,086.8	10,337.8
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	166.2	159.1	70.6
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	1,418.8	872.7	1,664.1
Хоёрдогч өглөг	-	-	-
Гаргасан өрийн үнэт цаас	-	-	670.6
Бусад өр төлбөр	260.5	172.7	137.3
Түрээсийн өр төлбөр	15.9	13.9	9.5
Орлогын татварын өглөг	55.7	76.9	77.2
Хойшлогдсон татварын өглөг	2.4	6.4	12.7
НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,476.8	10,758.2	13,384.4

Өөрийн хөрөнгө	2022	2023	2024
Хувьцаат капитал	323.8	340.9	340.9
Нэмж төлөгдсөн капитал	0.0	64.1	64.1
Дахин үнэлгээний нөөц	145.7	143.5	143.4
Борлуулах боломжит санхүүгийн хөрөнгийн хуримтлагдсан хэрэгжээгүй олз (гарз)	3.0	35.4	44.9
Тусгай зориулалттай нөөц	110.3	134.8	129.4
Хуримтлагдсан ашиг	595.3	689.8	893.4
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	1,178.0	1,408.4	1,616.0
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	9,654.8	12,166.6	15,000.4

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	2022	2023	2024
Хүүгийн орлого	674.1	764.7	1,086.0
Хүүгийн зардал	(354.5)	(469.0)	(602.5)
Хүүгийн цэвэр орлого	319.6	295.7	483.5
Шимтгэл, хураамжийн цэвэр орлого	50.4	61.4	76.6
Үйл ажиллагааны бусад орлого (алдагдал), цэвэр	13.9	54.7	87.9
Хүүгийн бус цэвэр орлого	64.4	116.1	164.6
Үйл ажиллагааны орлого	384.0	411.7	648.1
Үйл ажиллагааны зардал	(172.8)	(183.8)	(232.2)
Үнэ цэнийн бууралтын нөөцийн алдагдал	28.3	(35.4)	(22.6)
Хараат компанийн алдагдлаас ногдох хувь	0.4	4.3	(5.0)
Татварын өмнөх ашиг	239.9	196.8	388.2
Орлогын татварын зардал	(45.7)	(45.6)	(89.6)
Тайлант жилийн цэвэр ашиг	194.2	151.2	298.6

ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Ашигт ажиллагаа	2022	2023	2024
Зардлын орлогод эзлэх хувь	45.0%	44.6%	35.8%
Цэвэр хүүгийн зөрүү	4.4%	3.7%	5.3%
Өөрийн хөрөнгийн өгөөж	16.5%	10.7%	18.5%
Активын өгөөж	2.0%	1.2%	2.0%
Өсөлтийн харьцаанууд	**2022**	**2023**	**2024**
Активын өсөлт	1.1%	26.0%	23.3%
Зээлийн өсөлт	-9.8%	19.2%	25.3%
Харилцах, хадгаламжийн өсөлт	-0.9%	46.4%	13.8%
Өөрийн хөрөнгийн өсөлт	15.5%	19.6%	14.7%
Активын чанар	**2022**	**2023**	**2024**
Зээл / Харилцах, хадгаламж	66.7%	54.3%	59.8%
Зээлийн активт эзлэх хувь	42.9%	40.5%	41.2%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	43.4%	49.7%	49.5%
Өөрийн хөрөнгийн харьцаа	**2022**	**2023**	**2024**
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ	15.2%	16.6%	14.8%
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	15.2%	16.6%	14.8%

ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Хөгжил дэвшил, тогтвортой хөгжилд хамтдаа тэмүүлэн ажиллаж буй ажилтнууд болон ажилтнуудын бүтээж буй ололт амжилтууд нь ТиДиБи-ийн бахархал юм.
Худалдаа хөгжлийн банк нь Хүний нөөцийн бизнесийн партнер загварыг хэрэгжүүлэн оновчтой стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн үнэлгээ, тасралтгүй суралцагч соёл, залгамж халаа төлөвлөлт, ажилтны карьер хөгжил, шагнал урамшуулал зэрэг 2024 онд ажиллах хүчний сайн сайхан байдлын тэргүүн чиглэлийг тодорхойлон, түүнд голчлон анхаарч шинээр төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллалаа.

Бид 2024 ондоо 608 шинэ залуучуудыг ажилд авч, ажиллах хүчний тогтвортой байдлыг хангаж ажиллаж байна.

САНХҮҮГИЙН САЙН САЙХАН БАЙДАЛ

ГҮЙЦЭТГЭЛИЙН МЕНЕЖМЕНТ

Худалдаа, хөгжлийн банк нь Гүйцэтгэлийн менежментийн тогтолцоог 2023 оноос хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд улирал бүр банкны төвийн газар, нэгжийн ажилтнуудын бодит гүйцэтгэлийг хэмжиж, гүйцэтгэлийг нэмэгдүүлэх, чадавхийг хөгжүүлэх бодлогын түвшиний ажлуудыг хийж гүйцэтгэдэг. Гүйцэтгэлийн менежментийн тогтолцоог хэрэгжүүлэхэд программ болон ажилтны ажлын байрны дагуух бодит үр дүн бүхий гүйцэтгэлийг хэмжих ажлуудыг тогтмол сайжруулж, ажилтнуудыг мэдээллээр ханган ажиллаж байна.

ЦАЛИН УРАМШУУЛЛЫН СТРАТЕГИ

- "Зөгийн үүр хөтөлбөр" нь 4 жил тасралтгүй үргэлжлэх бөгөөд 2024 онд ч амжилттай хэрэгжиж Гүйцэтгэх удирдлагаас бусад ажилтнуудын Бүтээмжийн цалинг дахин 25 хувиар нэмэгдүүлэн ажиллаа. Мөн ажилтнуудын чадамж болон гүйцэтгэлд суурилсан нэмэгдэл цалингуудын үнэлгээг улирал, жил бүр тодорхойлж, түүнд тулгуурлан шийдвэр гаргалтуудыг гүйцэтгэж ажиллаж байна.
- Улирал бүр шилдэг ажилтнуудыг шалгаруулан 133 гаруй шилдэг ажилтнаа Турк улс, Чежу арал, Хайнань арал, Фукуок арлаар аялуулаа. Энэхүү аялал нь 2022 оноос хойш тасралтгүй хэрэгжиж байна.
- 200 гаруй ажилтнаа Монгол банк болон төрийн, төрийн бус шагналаар шагналаа.
- Тайлант хугацаанд ажилтнуудынхаа сайн сайхан, нийгмийн асуудлыг хүрээнд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлийн бүтээгдэхүүн олгож дэмжин ажиллалаа.

БИЕИЙН БОЛОН СЭТГЭЛ ЗҮЙН САЙН САЙХАН БАЙДАЛ

BENEFIT BOOK

ХХБ-ны үнэ цэнтэй ажилтнуудад Харилцагч байгууллагуудад хөнгөлөлтэй үнээр бүтээгдэхүүн, үйлчилгээг авах боломжийг олгож Benefit book-ийг 2023 оноос хойш баяжуулан ажиллаж байна.

САЙН ДУРЫН КЛУБУУД

Ажилтан хоорондын эрүүл харилцааг бий болгож, хадгалах, хамтын бүтээлч байдлыг нэмэгдүүлэх, ажилтнуудын сэтгэл ханамжийг өсгөх болон нийгмийн дэмжлэгүүдийг үзүүлж, сэтгэл хангалуун ажилтнуудыг бий болгох зорилгоор сайн дурын клубүүд үйл ажиллагаа явуулж байна. Өөрсдийн сонирхолын бүлгээрээ нэгдсэн клубүүд нийт ажилтны биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийн сайн сайхан байдлыг дэмжсэн олон үйл ажиллагаанууд зохион байгуулан ажиллаж байна.

Personal Development club
Good readers club
English speaking club
E-Sport club
Gender networking club
Hiking club
Well-being club
Football club
Well-being club
Podcast club

НИЙГМИЙН БОЛОН ГЭР БҮЛИЙН САЙН САЙХАН БАЙДАЛ

ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

Худалдаа, хөгжлийн банкны стратеги, урт хугацааны зорилго, зорилтод нийцсэн гүйцэтгэлийг бий болгоход нөлөөлөх түлхүүр ажлын байруудад ажиллах мэргэшсэн, туршлагатай ажилтныг бэлтгэж ирээдүйд үүсэж болох эрсдэлүүдийг бууруулж, амжилтын хурдыг хадгалах зорилгоор "ХХБ-ны Залгамж халааны бодлого" боловсруулагдлаа.

Банкны хэмжээнд түлхүүр ажлын байрыг тодорхойлж, тус ажлын байранд мэргэшсэн, өндөр ур чадвартай ажилтныг тасралтгүй бэлтгэх бодлогын хүрээнд албан тушаал бүрийн бэлтгэх хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлэн ажиллалаа.

КАРЬЕР МЕНЕЖМЕНТИЙН БОДЛОГО

"ХХБ-ны Карьер менежментийн менежментийн бодлого" батлагдсантай холбогдуулан уг бодлогыг ажилтнуудад хүргэх ажлын хүрээнд дотооддоо ERP системийн дэд систем болох цоо шинэ, сүүлийн үеийн дэвшилтэт программын хөгжүүлэлтүүдийг хийн нэвтрүүллээ.

Тус программ нь ажилтнуудын өөрийн зан төлөв, ур чадварт үндэслэн дараагийн карьер төлөвлөлтийг зураглаж, тус карьерт шаардлагатай ур чадваруудыг тодорхойлж өгч хамтран ажиллаж байна.

ТАСРАЛТГҮЙ СУРАЛЦАГЧ СОЁЛ

2024 онд нийт 499 удаагийн сургалтад давхардсан тоогоор 19,944 ажилтныг сургалтад хамруулав. 2024 онд нэг ажилтан хамгийн багадаа 1 сургалтад хамрагдаж, давхардаагүй тоогоор 1 ажилтан 8-9 удаагийн сургалтад хамрагдсан байна.

19815 ажилтан

498 төрлийн

8-9 цаг Сургалтын хугацаа /1 ажилтан/

Ажилтны тасралтгүй суралцах соёлыг бүрдүүлэх зорилгоор ажилтан бүр хүссэн газраасаа өөрийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэн Олон улсын Udemy платформтой 3 дахь жилдээ хамтран ажиллаж 115 төрлийн 918 цагийн 760 гаруй сургалтуудад хамруулж, сертификаттай болгосон. Мөн дотоод сүлжээнд дотоод сургагч багш нараар дамжуулан видео хичээл бэлтгэн ажилтнуудад нээлттэй үзэх боломжийг бүрдүүлсэн.

2024 онд шинээр хэрэгжүүлсэн томоохон онцлох хөтөлбөрүүд:

- Future leaders удирдах ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх хөтөлбөр
- Lady`s leadership" нярайн чөлөөнөөс эргэн ажилдаа томилогдон ажиллаж буй эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр
- Жендерийн сургагч багш бэлтгэх хөтөлбөр
- Ногоон санхүүжилт, тогтвортой хөгжлийн сургагч багш бэлтгэх хөтөлбөр
- Дижитал ур чадвар хөгжүүлэх хөтөлбөр
- Ментор - 2024 хөтөлбөр
- Coaching - 2024 хөтөлбөр
- TDB Knowledge sharing тэмцээн

НИЙГМИЙН БОЛОН ГЭР БҮЛИЙН САЙН САЙХАН БАЙДАЛ

ТОГТООН БАРИХ БОДЛОГО

Худалдаа, хөгжлийн банкны ажилтнуудыг идэвхжүүлэх, ажилтны оролцоог нэмэгдүүлж, бүтээмжийг дээшлүүлж, аз жаргалтай ажилтныг бий болгох зорилгоор ажилтнуудын эрэлт хэрэгцээг тодорхойлж, түүн дээр суурилан ажилтны сайн сайхан байдлыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ажиллаж байна. Тэргүүлэх 5 чиглэлийг тодорхойлж, түүнд тулгуурлан ажилтнуудад чиглэсэн томоохон бодлого, төлөвлөлт, ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

УЯН ХАТАН ЦАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СИСТЕМ

ХХБанкны "Ажилтан төвтэй Хүний нөөц"-ийн бодлогын хүрээнд газар, хэлтсийн ажилтнуудын ажиллах орчин, чөлөөтэй сэтгэх боломжийг бүрдүүлэх зорилгоор тус үйл ажиллагааг 2023 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

ЗАЙНААС АЖИЛЛАХ СИСТЕМ

Ажилтнуудын байршлаас үл хамааран бүтээмжийг нэмэгдүүлэх, ажил амьдралын тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор ажлын байрны онцлогоос хамаарч зайнаас ажиллах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

АЖИЛТНЫ СЭТГЭЛ ХАНАМЖ

Хүний нөөцийн оновчтой шийдвэр гаргалт, ажилтанд чиглэсэн бодлого төлөвлөлтийг гадаад болон дотоод орчны судалгаанд үндэслэн гаргадаг бөгөөд ажилтны сэтгэл ханамжийг судалгааг жил бүр авч ажиллаж байна. Банкны хэмжээнд ажиллаж буй ажилтнуудыг сэтгэл ханамжийн судалгааны үр дүн В үнэлгээтэй байна.

ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Худалдаа, хөгжлийн банкны өөрийгөө хөгжүүлэхээр олон улсын мэргэшсэн эрх олгох сургалт, шалгалтад амжилттай хамрагдсан ажилтнуудад төлбөрийн тодорхой хувийг банкнаас буцаан олгох замаар тэдгээрийг сурч, хөгжихөд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Дэмжих хөтөлбөр"-ийг жил бүр хэрэгжүүлэн ажиллаж байна.

TDB FLEXIBLE MOM ХӨТӨЛБӨР

Нярайн болон хүүхэд асрах чөлөөтэй ажилтнуудын нийгмийн сайн сайхан байдлыг дэмжиж, тасралтгүй хөгжүүлэх, нэмэлт орлоготой болох боломжийг олгох зорилгоор банкны "Харилцагчийн мэдээллийн хэлтэс"-т зайнаас ажиллуулаа. Тус хөтөлбөрийн сэтгэл ханамжийн үр дүн өндөр байгаа тул жил бүр хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

ДАСАН ЗОХИЦОХ ХӨТӨЛБӨР

Шинээр томилогдон ажиллаж буй ажилтнуудаа халамжлах, сургаж хөгжүүлэх зорилгоор дасан зохицох хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус хөтөлбөрт тухайн ажилтны удирдлагын арга барил, хамт олны соёл, эерэг уур амьсгал шууд нөлөөтэй бөгөөд тогтмол судалгаа авч сайжруулан ажиллалаа.

ЭРАСМУС ХӨТӨЛБӨР

Санхүү эдийн засгийн их сургуультай хамтарсан "Ажлын байранд суурилсан цалинтай дадлагажих-Erasmus" хөтөлбөрийг хэрэгжүүлэн банкны газар нэгжид дадлага хийлгэх, улмаар цаашид төгссөний дараа банкны шууд ажлын байран дээр томилох зорилгоор цалинтай болон цалингүй дадлагыг хамтран амжилттай зохион байгуулаа. Тус хөтөлбөрт амжилттай хамрагдсан оюутан залуус ажлын байран дээр томилогдон ажиллаж байна.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Уламжлал болсон худалдааны санхүүжилтийн форумаа зохион байгууллаа. Худалдаа, үйлчилгээний бизнесийн орчныг шинээр харж, сорилт бэрхшээл, амжилт ололт, шинэ боломжийг хүндэт харилцагч, бизнесийн итгэлт түншүүдтэйгээ хамт хэлэлцлээ.

WELCOME TO MONGOLIA УРИАТАЙ монголын эдийн засгийн форум 2024 арга хэмжээг ХХБ дэмжин ажиллав. Форумын үеэр өөрсдийн тогтвортой санхүүжилтийн чиглэлийн ажлуудыг онцоллоо.

Монголд анх удаа олон улсын хамгийн том боловсролын арга хэмжээ болох STEAMEX 2024 зохион байгуулагдсан. Тус арга хэмжээний үеэр бага ангийн болон байгалийн ухааны багш нарыг чадавхжуулах 100% практик туршилт, бүтээлд суурилсан хөтөлбөрт 21 аймаг бүрээс оролцох 100 багшийн төлбөрийг ХХБ төллөө.
Мөн банкны үйл ажиллагаанд ашиглах боломжгүй техникийн хог хаягдлууд Дүдэ хүүхдийн музейд хандивласан. Тухайн музей нь тус хог хаягдлыг шинжлэх ухаанд сонирхолтой бага настай хүүхдүүдийн дунд зохион байгуулах Workshop-тоо ашиглах, ашиглаж дуусаны дараа байгальд ээлтэйгээр хог хаягдал дахин боловсруулдаг үйлдвэрт хандивлах юм.

Эрчим хүчний зохистой хэрэглээг дэмжих "ТОГ-оо тохируулъя" аянд нэгдэж гэрэл цахилгаан хэрэгслээ цахилгаан зарцуулалт бага хэрэгслээр сольж, эрчим хүчний өндөр хэрэглээтэй цахилгаан хэрэгслээ ачаалал багатай үед ажиллуулж байна.

MONGOLIAN BUSINESSES VIP NETWORKING EVENT

ХХБ Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж буй олон улсын байгууллагууд болон элчин сайдын яамнуудтай өргөн хүрээний харилцаа, хамтын ажиллагаатай ажилладаг. Энэ хүрээндээ бид Франц-Монгол болон Америк-Монгол хоёр орны хооронд бизнес эрхэлдэг бизнес эрхлэгч нартаа зориулсан VIP хүлээн авалт зохион байгуулаа.

Bloomberg TV Mongolia 2013 оноос эхлэн жил бүр Монгол Улсын эдийн засгийн өсөлт, хөгжил дэвшилд томоохон хувь нэмэр болсон хамгийн шилдэг бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, бодлого шийдлийг "Bloomberg Awards"-т нэр дэвшүүлэн манлайлагчдыг тодруулж ирсэн. Энэ жилийн хувьд тус санаачилгын дараагийн хуудсыг нээж, тогтвортой хөгжил, ногоон эдийн засагт хүргэх "хурдасгуур" болж буй шилдгүүд буюу "Catalyst"-уудыг тодруулаа. Арга хэмжээний ерөнхий ивээн тэтгэгчээр Худалдаа Хөгжлийн Банк ажиллалаа.

СЕКТОРЫН ХАМГИЙН ӨНДӨР ЦАЛИН

Банкны ажилтнуудын сэтгэл ханамж, сайн сайхан байдал, амьдралын чадавхыг дээшлүүлэх зорилгоор нийт ажилтнуудын бүтээмжийн цалинг дахин 25 хүртэлх хувиар нэмлээ.

Жижиг дунд бизнес эрхлэгч, эмэгтэйчүүдийг дэмжих, бизнесийн боломжуудыг танилцуулах, олон улсын байгууллагын сургалт зөвлөгөөг хуваалцаж, хамтран ажиллах боломжтой корпорэйт байгууллагуудтай танилцуулах зорилгоор "Be Lady Forum" зохион байгуулаа.

ХЯЗГААРГҮЙ МОРООДОЛ

Тайлант онд гурван удаа Хязгааргүй мөрөөдөл төслөө хэрэгжүүллээ. Ингэхдээ Дэлхийн Аутизмын сарыг тохиолдуулан аутизмтай онцгой хүүхдүүдэд зориулан Онцгой Хүүхдүүдийн Академид "хүүхдүүд дүрд орж тоглох сургалтын өрөөг иж бүрэн тохижуулж" өгсөн. Дараагийн удаад нь "Аутизм Анд ТББ"-ын дэргэдэх "Анүүлэн аз жаргал" цэцэрлэгийн сургалтын анги танхимыг нь бүрэн тохижуулж өглөө.

Мөн дэлхийн хуримтлалын өдрийг тохиолдуулан Налайх дүүргийн Голомт цогцолбор сургуулийн номын санг тохижуулж, номоор баяжуулж өглөө.

Ийнхүү Хязгааргүй мөрөөдөл төсөл нийт 58 сургууль цэцэрлэгийн 200 мянга гаруй хүүхэд, 10000 гаруй багш, сурган хүмүүжүүлэгчдийн боловсролд оюуны хөрөнгө оруулалт хийгээд байна. Бид цаашид ч нийгмийн хариуцлагын хүрээнд уг төслөөр дамжуулж, Монголын хойч ирээдүй болсон хүүхэд, залуусыг сурч боловсрох боломжоор дэмжин ажиллах болно.

МААМУУ ХҮҮХДИЙН ХАДГАЛАМЖ

АНУ-ын "ABC" телевизийн уран бүтээл Bet on Baby шоу нэвтрүүлгийг албан ёсны эрхтэйгээр Монголд анх удаа NTV телевиз хургэсэн. ХХБ МААМУУ хүүхдийн хадгаламжаар дамжуулан олон нийтэд санхүүгийн боловсрол олгох чиглэлд хамтран ажиллаа.

Мөн бага насны хүүхдүүдийн гэгээн хүсэл мөрөөдлийг сонсож , Сантатай уулзах хүсэл биелүүлэх болон хүүхдүүдээр дамжуулан санхүүгийн боловсрол олгох зорилготой Маамуу хүүхдийн контентыг бэлтгэн сошиал медиагаар олон нийтэд хүргэв.

БИЗНЕСИЙН ОРЧИН

Тайлант онд EuroCham - Global Gateway project - opportunities for companies in Mongolia, AmCham Mongolia – CSR AWARDS 2024, Logistic Forum 2024, SIBOS 2024, Japan festival in Mongolia 2024, U.S. Embassy - WOMEN ENTREPRENEURS, MinigWeek & MinePro 2024, TDB and Chiba Bank networking зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, дэмжин ажиллаа. Ингэснээр Худалдаа, хөгжлийн банк Монгол Улс болон гуравдагч хөрш улс хоорондын бизнесийн нөхцөл байдал, эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэлээ.

НЯРАЙН ШАРЛАГЫН АППАРАТ

ХХБ-ны ууган салбаруудын нэг Эрдэнэт салбарын үүсгэн байгуулагдсаны түүхт 25 жилийн ой тайланд онд тохиож байна. Ойн баяраараа ХХБ эх үрсийн эрүүл мэндийг дэмжих, эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор "Орхон аймаг дахь Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төв"-д нярайн шарлагын аппарат бэлэглэлээ.

WORLD ECONOMIC FORUM

Дэлхийн Эдийн Засгийн Форум, өвлийн болон зуны Давос форумд ХХБ-ыг төлөөлж ТУЗ-ийн дарга Рандолф Коппа, ГЗО Н.Сэргэлэн нар оролцлоо. ХХБ дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн, Монгол Улсын шилдэг олон улсын банк болохынхоо хувьд 2010 оноос хойш Дэлхийн Эдийн Засгийн Форумтай хамтран ажилласан юм.

Bloomberg LED MEDIA SCREEN

Төр болон хувийн хэвшлийн байгууллагаас хэрэгжүүлж буй нийгэм, байгаль дэлхийн сайн сайхны төлөөх үйл ажиллагаануудыг дэмжиж ажиллав. Дэмжлэгийн хүрээнд 4 байгууллагын 13 төрлийн видеог төв байрны гадаа байрлах дэлгэцээрээ тус бүр 14 хоногоос дээш хугацаанд үнэгүй байршуулла.

DFC U.S. International Development Finance Corporation

TDB&DFC

ХХБ АНУ-ын Засгийн газрын Хөгжлийн Санхүүжилтийн Корпорацтай урт хугацааны санхүүжилтийн гэрээг үзэглэлээ. Энэхүү гэрээг үзэглэснээр Монгол Улсаас банк санхүүгийн байгууллага ХСК-аас шууд санхүүжилт босгосон анхны тохиолдолд болж байгаагаараа онцлог юм. Тус санхүүжилтийг авснаар Монгол Улс дахь бичил ба жижиг, дунд үйлдвэрлэл (БЖДҮ), эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд, мөн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд дамжуулан зээл олгох замаар тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх боломжийг бий болголоо.

ЖДҮ-ИЙГ ДЭМЖИГЧ

ХХБ Нийслэлийн Жижиг, Дунд Үйлдвэрлэл, Үйлчилгээг Дэмжих Төв НӨҮГ, Зээлийн Батлан Даалтын Сантай хамтран Улаанбаатар хотын ЖДҮҮ эрхлэгч нарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэхээр боллоо. Тус хөтөлбөрөөр дамжуулан жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгынхоо хүрээнд бодит хэрэгцээ шаардлага бүхий ЖДҮҮ эрхлэгч нарт хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл олгоно. Ингэснээр бизнес эрхлэгчдийн зах зээлд өрсөлдөх чадвар, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх, салбарын хэмжээнд улсаас хэрэгжүүлж буй бодлогод хувь нэмэр оруулан дэмжлэг үзүүлэх том алхам болох юм.

НИЙГМИЙН БОЛОН НОГООН БОНД

Худалдаа Хөгжлийн Банк Монгол Улсаас анх удаа Олон улсын мэргэжлийн хөрөнгө оруулагчдад зориулсан Нийгмийн болон Ногоон бондыг хаалттай хэлбэрээр Австри Улсын Венийн Хөрөнгийн Бирж дээр гаргалаа. Нийгмийн болон Ногоон бонд дэлхийн ТОП-10-т эрэмбэлэгддэг Ассет Менежментийн Компаниас хөрөнгө оруулсан нь Монгол Улсын хувьд түүхэн амжилт байлаа.



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

БАЙГУУЛЛАГЫН ЗАХ ЗЭЭЛ

Худалдаа хөгжлийн банк нь Харилцагч төвтэй Байгууллагын банк байх, олон улсын жишиг стандартад нийцсэн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, нутагшуулах, бүтээгдэхүүний үр ашгийг нэмэгдүүлэх, ногоон бизнесийг дэлгэрүүлэх зэрэг томоохон зорилтуудыг тавьж ажиллаж байна.

Харилцагч төвтэй банк болох урт хугацааны стратеги зорилгын хүрээнд харилцагчдын эрэлт хэрэгцээ, зан төлөв, бизнесийн онцлогт нийцсэн үйлчилгээг санал болгох, харилцагчаа халамжлах, харилцагчид хүрэх үнэ цэнийг нэмэгдүүлэн, харилцан ашигтай урт хугацааны хамтын ажиллагаанд зорьж ажиллаж байна.

2024 оны хувьд эдийн засгийн хөдөлгөгч хүч болсон уул уурхай, худалдаа үйлчилгээ, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, барилга гэх мэт салбаруудын манлайлагч 2800 гаруй групп болон томоохон аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллаа. Тэдний санхүүгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн зээл, депозит, худалдааны санхүүжилт болон төлбөр тооцооны 60 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож, харилцагчийн бизнесийг дэмжин, хамтын өсөлтийг бий болголоо.

ЗЭЭЛ, ЭХ ҮҮСВЭР, ТӨЛБӨР ТООЦОО

Банкны секторын том ААН-үүдэд олгосон зээлийн 30 орчим хувийг, эх үүсвэрийн 20 гаруй хувийг Худалдаа хөгжлийн банкны Байгууллагын харилцагчид бүрдүүлж байна.



Мөн харилцагчийн ханшийн эрсдэл, төслийн цар хүрээнд нь тулгуурлан урт хугацааны хөнгөлөлттэй эх үүсвэрийг санал болгох, ногоон болон эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх стратегийн хүрээний гадаад эх үүсвэрүүдийг татаж, харилцагч нарынхаа бизнесийн онцлогт тулгуурлан санал болгож байна.

Олон улсын бизнес модель SUBSCRIPTION буюу захиалгат төлбөрийн системийг банкны төлбөр тооцооны бүтээгдэхүүн дээр суурилан анхлан нэвтрүүлж ажиллаж байна.

ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТ

Эдийн засгийн нөхцөл байдал сайжирч, гадаад худалдааны эргэлт нэмэгдэхийн хэрээр импорт, экспортын аккредитив болон инкассын үйлчилгээгээр бизнес эрхлэгчид эрсдэлээ бууруулах, үйл ажиллагааны зардлаа хэмнэх, илүү хялбар санхүүгийн хэрэгсэл ашиглуулах байдлаар хамтын ажиллагаа тэлсээр байна.
2024 онд Худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүний зах зээлд эзлэх хувийг 39%-д хүргэж, байгууллагын сегментийн харилцагчдад гаргасан нийт аккредитив, баталгааны дүнг өмнөх оны эцсээс 14%-аар нэмэгдүүлэн ажиллаа.
Мөн дотоодын нийлүүлэлт болон экспортыг нэмэгдүүлэх зорилгоор

3F буюу
Freight forward financing
Factoring
Forfaiting

бүтээгдэхүүнүүдээр дамжуулан харилцагчдын бизнесийн эргэцийг дэмжин ажиллаж байна.

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

Монгол улсын Засгийн газрын урт болон богино хугацааны төлөвлөгөө, мега төсөл хөтөлбөр үүнийг даган хэрэгжиж буй төслийн зээлийн санхүүжилт дээр идэвхтэй оролцож сектор бүрийг дэмжих хөтөлбөрүүдэд түлхүү оролцож байна. Тухайлбал өнгөрсөн онд МУ-ын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Хүнсний хувьсгал", "Цагаан алт" зэрэг хөтөлбөрүүдийг дэмжин тэргүүлэгч банк болон ажиллаж байна.
ХХБ нь нийгмийн хариуцлагын хүрээнд газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, зоорь агуулах, хүүхдэд чиглэсэн сүү, сүүн бүтээгдэхүүн, талх нарийн боов, гурилын үйлдвэрлэл, махны үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбар гэх мэт төслүүдийг идэвхтэй дэмжиж байна. 2024 онд тус чиглэлд нийт 147.5 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын санхүүжилт олгоо.

ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД:

2025 онд "Цагаан алт" хөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй "Ноос, ноолуур, арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын зээл"-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээг ХХААХҮЯ-тай байгуулж, харилцагчдын зээлийн хүсэлтийг шийдвэрлэхээр судалгаанд авч эхэллээ.



ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСИЙН ЗАХ ЗЭЭЛ

Худалдаа, хөгжлийн банк нь "Харилцагч төвтэй банк болох" урт хугацааны стратеги чиглэлийн хүрээнд жижиг, дунд бизнесийн сегментийн зах зээлд эзлэх байр суурийг өргөжүүлэн тэлж ажиллав.

Жижиг, дунд бизнес эрхлэгч иргэд аж ахуй нэгжүүдийг чадавхжуулах, бизнесийн онцлогт тулгуурласан төлөвлөгөө гаргах, үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, удирдлагын арга барилыг сайжруулах, банкны бүтээгдэхүүн үйлчилгээг оновчтойгоор ашиглах, хямд өртөг бүхий эх үүсвэрийг хэрхэн зөв зохистой ашиглах зэрэг олон төрлийн зөвлөгөө сургалт, үйлчилгээгээр ханган ажиллаж байна.

Жижиг дунд бизнесийн сегмент нь иргэн болон байгууллагыг багтаасан онцлог сегмент бөгөөд сегментийн идэвхтэй 86,815 жижиг, дунд бизнес эрхлэгч харилцагч нарт банкны суурь бүтээгдэхүүн үйлчилгээг салбар, тооцооны төвүүд болон цахим сувгуудаар дамжуулж олон улсын стандартыг суурь болгож санхүүгийн эко систем үүсгэж хамтран ажиллаж байна.

Тайлант онд жижиг, дунд бизнес эрхлэгчдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 1,200.79 тэрбум төгрөг болж, өөрийн банкны зээлийн багцын 19%-ийг бүрдүүлж байна. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн хувьд 1,505.45 тэрбум төгрөг болж, өөрийн банкны татан төвлөрүүлсэн хөрөнгийн 16%-ийг эзэлж байна.

SME ХАРИЛЦАГЧ



Жижиг, дунд бизнесийн сегмент нь тайлант онд чанаргүй зээлийг төлүүлэх ажиллагааг шат дараатай хэрэгжүүлсний үндсэн дээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад чанаргүй зээлийн хэмжээ 9.7%-аар буурсан үзүүлэлттэй байлаа.

ЖИЖИГ, ДУНД СЕГМЕНТИЙН БИЗНЕС ЭРХЛЭГЧ БАЙГУУЛЛАГА



ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

"ПОС МЕРЧАНТ - ИРГЭН" БАГЦ БҮТЭЭГДЭХҮҮН

ХХБ-ны ПОС төхөөрөмжийг ашигладаг бизнес эрхлэгч иргэдийн ашигладаг банкны бүтээгдэхүүн үйлчилгээг багцлан, хөнгөлөлттэй нөхцөлөөр санал болгож харилцагчийн цагийг хэмнэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний ашиглалтыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилготой шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн.

"DFC ЭХ ҮҮСВЭРТЭЙ ЗЭЭЛ"

"U.S. International Development Finance Corporation"-с санхүүжилт авсантай холбоотойгоор тус эх үүсвэрээр олгогдох "Эмэгтэй бизнес эрхлэгчийг дэмжих зээл", "Бизнесийн жижиг зээл", "Ногоон зээл"-ийг тус тус зах зээлд нэвтрүүлсэн.

"НИЙСЛЭЛИЙН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТӨВ НӨҮГ", ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН-ТАЙ ХАМТАРСАН ХӨНГӨЛӨЛТТЭЙ НӨХЦӨЛ БҮХИЙ ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

"Улаанбаатар хотын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хүрээнд хүү багатай, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч нарт олгож эдийн засгийн бодит хувь нэмэр оруулж байна.

ИРГЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Тайлант хугацаанд ХХБ-ны иргэдийн сегментийн зах зээлд эзлэх байр суурьиа нэмэгдүүлж, харилцагч нарт банкны бүтээгдэхүүн үйлчилгээг зайнаас хүргэх, үүний тулд харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээндээ инновац шингээсэн хялбар шийдэл санал болгох чиглэлд түлхүү ажилласан.

Иргэдийн зах зээлийг тэлэх банкны дунд хугацааны зорилтын хүрээнд харилцагчдын тоогоо өмнөх жилийн мөн үеэс 17%-р өсгөж 1,095,421 харилцагчтай боллоо.



ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

ЗЭЭЛ

Бид хурдацтай хөгжиж буй зах зээлд харилцагчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн бүх төрлийн санхүүгийн хэрэгцээ шаардлагыг хангахуйц бүтээгдэхүүн үйлчилгээг цахим сувгаар богино хугацаанд хүргэхийг зорин ажиллаж байна.

Үүний хүрээнд бид хэрэглээний зээлийн хүсэлтийг зайнаас түргэн шуурхай шийдвэрлэн харилцагчийн сэтгэл ханамжийн индексийг хамгийн өндөр түвшинд байлгах үндсэн зорилгоо биелүүлэн ажиллаж байна. Үүний үр дүнд бид 16 мянган харилцагчийн хэрэглээний санхүүгийн асуудлыг шийдэж, багцаа 303%-аар нэмэгдүүлсэн байна.

ХУРИМТЛАЛТАЙ МОНГОЛ

Бид харилцагч нартаа бусад банкнуудаас илүү уян хатан нөхцөлтэй хадгаламжийн бүтээгдэхүүнийг цахим сувгаар илүү өгөөжтэйгээр санал болгож, Монгол улсын иргэн бүрийг хуримтлалтай болгох хуримтлалын ач тусыг таниулан мэдүүлэх, түүнийг нь урамшуулах зорилготой Хуримтлалтай Монгол аяныг 5 дахь жилдээ хэрэгжүүлээ. Ингэхдээ харилцагч санхүүгийн дарамтгүйгээр хуримтлуулах боломжийг бүрдүүлсэн Хялбар хуримтлал үйлчилгээтэй уялдуулан ажиллаа. Үүний үр дүнд хугацаатай хадгаламжийн эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 18%-ийн өсөлт үзүүлсэн байна.

ХЯЛБАР ХУРИМТЛАЛ

ДААТГАЛ

Бид даатгал зуучлалын үйлчилгээндээ харилцагчийн эрх ашиг бүрэн хамгаалагдаж, гэрээний дагуу даатгалын хамгаалалтаа авч байх зарчмыг нэн түрүүнд баримталж ажилладаг ба энэ хүрээндээ харилцагч, даатгуулагч нартаа олгуулсан нөхөн төлбөрийн хэмжээ өнгөрсөн оноос 5.8%-аар өссөн байна.

Түүнчлэн зуучлалын үйлчилгээний гол зорилго нь талуудын эрх ашгийг харилцан эрх тэгш байлгахад оршдог ба бид хамтран ажиллагч даатгалын компаниуддаа төвлөрүүлсэн хураамжийн орлого мөн өнгөрөгч оноос 42%-аар өссөн байна.

ТАЙЛАНТ ОНД ОНЦЛОХ

АГЕНТ БАНК

ХХБ-ны салбар байршдаггүй бүсүүдэд банкны бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх зорилгоор Агент банкны үйлчилгээг зах зээлд анхлан нэвтрүүлсэн. Үүний үр дүнд 11 аймаг, дүүргийн харилцагчдад хүрч ХХБ-ны бүхий л төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг онлайнаар ашиглах боломжийг бүрдүүлсэн.

ЗАЙНААС ХАРИЛЦАГЧ БҮРТГЭХ

Бид харилцагчдаа улам ойртож, монгол улсын иргэн дэлхийн хаанаас ч ДАН системээр өөрийгөө баталгаажуулан ХХБ-ны харилцагч болох боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр биетээр салбарт ирэх процессыг халж, харилцагчийн цаг хугацааг хэмнэх, салбарын ачааллыг бууруулж харилцагчийн сэтгэл ханамжийн индексийг хамгийн өндөр түвшинд байлгах үндсэн зорилгоо биелүүлэн ажиллаж байна.

МАСТЕР ВИРТУАЛ КАРТ

Дэлхийн жишигт нийцсэн төлбөрийн хэрэгслийн сувгийг тэлэх зорилгоор, олон улсын Мастер виртуал картыг зах зээлд нэвтрүүлсэн.

ЦАХИМ ХУДАЛДАН АВАЛТЫН ЗЭЭЛ

Биет худалдаа эрхэлдэг хувь хүн болон байгууллагуудын цахим хуудсаар дамжуулан харилцагч цахимаар 5 минутад зээлийн хүсэлтээ шийдвэрлүүлэн хүссэн бараа, бүтээгдэхүүнээ авах боломжтой болсон.

ЦАХИМ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

КАРТ, ТӨЛБӨР ТООЦОО

2024 онд бид харилцагчдын хэрэгцээнд тулгуурлаж инновац шингэсэн, хүлээлтээс давсан бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох, үйлчилгээний чанарыг сайжруулахад онцгойлон анхаарч ажиллалаа.

Тайлант онд төлбөрийн карт хэрэглэгчдийн тоо 24%-аар нэмэгдэж, Монгол улсын Виза картаар гадаадад хийгдэж буй гүйлгээний 33%-аас дээш хувийг ХХБ-ны Виза карт бүрдүүлж байна.

24%
Карт эзэмшигчид

33%
Гадаадад хийгдсэн гүйлгээний зах зээлд эзлэх хувь

UnionPay картын гүйлгээ өмнөх оноос 23%-ийн өсөлт үзүүллээ. Учир нь БНХАУ-д хийсэн гүйлгээний үнийн дүнгийн 5% буцаан олголт, олон улсад хийсэн гүйлгээний үнийн дүнгийн 5% **буцаан олголт**ыг тус тус харилцагчдадаа олголоо. Харилцагчдад олгосон ба үүний хүрээнд БНХАУ-д картаараа худалдан авалт хийсэн үнийн дүнгийн 1% байнгын буцаан олголттой шинэ төрлийн SplendorPlus картыг зах зээлд нэвтрүүллээ.

Төлбөрийн картын Олон улсын тэргүүлэгч байгууллага болох VISA Inc-тай стратегийн түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд Paris Olympics 2024 идэвхжүүлэлтийн аяныг зохион байгуулж, Paris 2024 Summer Olympic Games Hospitality package ялагчийг тодрууллаа.

VIRTUAL CARD

2024 онд бид харилцагчдын хэрэгцээнд тулгуурлаж инновац шингэсэн, хүлээлтээс давсан бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох, үйлчилгээний чанарыг сайжруулахад онцгойлон анхаарч ажиллалаа.

Your iPhone is your TDB card.



ХХБ нь харилцагч нартаа зориулан төлбөр төлөх илүү аюулгүй, найдвартай, нууцлалтай Apple Pay үйлчилгээг зах зээлд нэвтрүүллээ. Ингэснээр харилцагч картаа Apple Pay-тэй холбон өөрийн iPhone, Apple Watch, iPad, Mac-аа ашиглан төлбөр тооцоогоо хийдэг боллоо.

ХХБ-ны Qpay үйлчилгээнд Монголбанкнаас баталсан шинэ стандарт руу шилжиж, худалдан авалтын гүйлгээнд хэрэглэгчээс нэмэлт шимтгэл авдаггүй боллоо. ТиДиБи Онлайн банкны хэрэглэгчдийн тоо өмнөх онтой харьцуулахад 23.5%-аар өссөн үзүүлэлттэй байсан бол банкны цахим сувгаар хийгдсэн гүйлгээний тоо 48%-аар тус тус нэмэгдлээ.

24%

Хэрэглэгчдийн тоо

48%

Гүйлгээний дүн

ТиДиБи Онлайн үйлчилгээний аппликэйшн хувилбарын системийн архитектурыг шинэчилснээр системийн ачаалал даах чадвар нэмэгдэж, мобайл аппликейшнын ажиллах хурд нэмэгдлээ.

Байгууллагад зориулсан Corporate gateway үйлчилгээний суурь системд шинэчлэл хийн, холболтыг Open API-д шилжүүлсэн ба харилцагчдын хүсэлтийг зайнаас шийдвэрлэх боломжтой болсон.

ONDO

Үүрэн телефоны Ondo-ийн дугаарт банкны мессеж мэдэгдэл очих боломжтой болсноор Монгол улсын аль ч үүрэн телефоны дугаарт банкны мэдэгдэл, мэдээллүүд илгээгддэг боллоо.

КЛИРИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Худалдаа, хөгжлийн банк дунд хугацааны стратеги зорилгынхоо хүрээнд "Нээлттэй банк" болохоор ажиллаж байна. Энэ хүрээндээ Монгол Улсын картын зах зээлийг хөгжүүлэх ажлыг анхлан эхлүүлсэн. Өнөөдрийн байдлаар өөрийн картын дэд бүтэц, системийн үйлчилгээг арилжааны дөрвөн /4/ банканд үзүүлж байна. Бид Монгол Улсын хэмжээнд банкны системийн карт, бэлэн бус төлбөр тооцооны найдвартай, аюулгүй байдлыг хангахад бодит хувь нэмрээ оруулж ирсэн. Мөн арилжааны банкнуудын зардлыг хэмнэн, үр ашигтай ажиллагааг нэмэгдүүлэн, хамтдаа хөгжих ажилд манлайлдаг билээ.

Энэхүү манлайллын хүрээнд Төлбөр тооцоо төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрлийг Монголбанкнаас хүлээн авсан ба финтек, банк бус санхүүгийн байгууллагын төлбөр тооцоог Монголбанкан дахь дансаараа дамжуулан төлбөрийн системд оролцох гарцыг нээж өгөх, нөгөө талдаа хэрэглэгч болон харилцагчдад дэвшилтэт технологид суурилсан санхүүгийн олон төрлийн үйлчилгээг хялбар, түргэн шуурхай хүргэхээр зорьж байна.

КАПИТРОН БАНК

АРИГ БАНК

БОГД БАНК
ИТГЭЛ ТҮГЭЭНЭ

bank national

ГАДААД ХАРИЛЦАА, ОЛОН УЛСЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бид бизнесийн үйл ажиллагаандаа тогтвортой, хариуцлагатай байдлыг чухалчлан байгаль орчинд ээлтэй бизнесийг дэмжин санхүүжүүлэх замаар урт хугацааны тогтвортой хөгжлийг бий болгох зөв жишгийг нийгэмдээ бүтээхээр ажилладаг.

Нидерландын Хөгжлийн Банк (FMO), Олон улсын санхүүгийн корпорац (OYCK)-тай хамтран 2012 онд "Байгаль орчин, нийгмийн хариуцлагын эрсдэлийн менежментийн систем" (БОНХМС) хэмээх Монгол Улсын хувьд цоо шинэ ойлголтыг цогцоор нь хэрэгжүүлж эхэлсэн Монголын анхны арилжааны банк болсон юм. 2013 оны 11-р сард Монголын нийт арилжааны банкнууд "Монгол улсын Тогтвортой Санхүүжилт (ToC) - ийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хамтарсан тунхаг бичигт нэгдсэн нь манай улсын ирээдүйн хөгжилд хэрэгтэй томоохон дэвшил болсныг онцлон тэмдэглэж байна. Арилжааны банкууд нэгдэн ажилласнаар амьдрах орчин болох ус, хөрс, агаарын бохирдол, цаг уурын өөрчлөлт, хүний эрхийг зөрчсөн асуудлуудын эсрэг бат зогсож, байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах замаар тогтвортой хөгжлийг бий болгох хэтийн зорилго өөд тэмүүлж байна.

Банк 2020 онд шинэ бүтэц зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа эрхэлж Ногоон санхүүжилтийн албыг (НСА) Олон улсын банкны газрын Гадаад эх үүсвэрийн удирдлага, хяналтын хэлтсийн харьяанд шинээр байгуулсан. НСА нь олон улсын сайн туршлагыг банканд нэвтрүүлэх, төсөл хөтөлбөрт хамтын санхүүжилт татах чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.

Монгол Улс дахь Жижиг, дунд бизнес ("ЖДБ") эрхлэгчдийг чадавхжуулах, тогтвортой санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах "SFME" төслийг хамтран хэрэгжүүлэхээр ХХБ болон Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг ("GIZ") нар төсөл хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурсан ба уг төсөл нь 2024 оны 3-р сараас 2026 оны 6-р сар хүртэл хугацаанд хэрэгжих бөгөөд Монгол улсын тогтвортой хөгжил болон ногоон ирээдүйд чиглэсэн ЖДБ-ийг дэмжих, ЖДБ эрхлэгчдэд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой юм.

Түүнчлэн ХХБ нь Даян дэлхийн ногоон хөгжлийн институт (ДДНХИ)-тэй стратегийн түншлэлийг бий болгож, улс орныхоо тогтвортой бөгөөд нүүрстөрөгчийн хий багатай эдийн засгийн өсөлтийг хурдасгахын тулд хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна. Тус хамтын ажиллагааны хүрээнд ХХБ болон ДДНХИ хамтран нэг талаас ЖДҮ-ийн харилцагчдад бизнесийн үйл ажиллагааг нь ногооруулах боломжуудын талаар мэдлэг солилцох уулзалт, нөгөө талаас банкны ажилтнуудад боломжит ногоон төслүүдийг танин мэдэх, тэдгээрт хяналт тавих, тайлагнах, баталгаажуулах (MRV) зэрэг чадавхыг бэхжүүлэх сургалтуудыг идэвхтэй зохион байгуулсан байна.

ХХБ нь харилцагчдадаа бизнесийн үйл ажиллагааг ногооруулах шийдлийг таниулах, эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих загварт шилжихэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 2024 оны 6-р сард "Ногоон барилга" воркшоп арга хэмжээг амжилттай хэрэгжүүллээ.



БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО

ХХБ-ны байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлогын хүрээнд бид МУ-ын зохих хууль тогтоомж болон дүрэм зааврыг баримталж ажиллахаас гадна бид дараах зарчмуудыг хэрэгжүүлж, дагаж мөрдөхийг зорьж байна:



НҮБ-ын Даян дэлхийн гэрээний арван зарчим;

Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)-ийн Гүйцэтгэлийн найман стандарт;

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүгийн санаачилга: Байгаль орчны болон тогтвортой хөгжлийн талаарх санхүүгийн байгууллагуудын тунхаглал; Үндэстэн дамнасан корпорац болон нийгмийн бодлогын талаарх Олон улсын хөдөлмөрийн байгууллагын зарчмын гурван талт тунхаглал;

МУ-ын Тогтвортой санхүүгийн холбоо (ToC холбоо)-ны Тогтвортой санхүүжилтийн найман зарчим;

Бүс ба Зам санаачилгын Ногоон хөрөнгө оруулалтын долоон зарчим;

ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН БОДЛОГО

ХХБ нь 2019 онд бүрэн шинэчлэгдсэн "Жендерийн эрх тэгш байдлын бодлого"-г олон улсын стандартад нийцүүлэн баталж, банкны жендерийн эрх тэгш байдлын үйл ажиллагааг хангах Жендерийн Хороог байгуулсан байна. Уг бодлогоор эрх тэгш байдлыг хангахад шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх, эмэгтэйчүүдийг чадавхжуулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх, мэдлэгийг бий болгох, жендерийн харьцааг тэнцвэржүүлэх, ялган гадуурхалтаас сэргийлэхэд оршино. Түүнчлэн бодлогын хэрэгжилтийн хүрээнд ХХБ нь эмэгтэй жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэн, харилцагчдадаа олгон ажиллаж байна. Түүнчлэн, бид 2019 онд Жендерийн Хороог байгуулан, байгууллагын бүхий л түвшинд Жендерийн эрх тэгш байдлын бодлогын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Энэхүү бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг МУ-ын Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр болон бусад олон улсын байгууллагуудын тэргүүн туршлагыг харгалзсан ба НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын Жендерийн эрх тэгш байдлыг хангах зорилго, зорилтуудыг дэмжин ажиллахаар зохицуулагдсан болно. Түүнчлэн МУ-ын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021 он), Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагийн жендерийн бодлого (2016-2024)-д нийцсэн болно.

Жил бүр Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, ToC Холбоо хамтран тогтвортой санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан, салбартаа манлайлагч байгууллагуудыг тодруулдаг уламжлалтай. Тус холбооноос 2024 онд жендерийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлуудыг үнэлэн, ХХБ-ыг "Жендерийн Манлай Байгууллага"-аар шалгаруулсан байна.



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХАМТДАА

ХХБ нь Монгол Улсад тогтвортой санхүүжилтийг дэлгэрүүлэх зорилгоор Бизнесийн ногоон зээлийн бүтээгдэхүүн болон Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэв. 2020 оноос хойш ХХБ нь Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг хэрэгжүүлж байгаа ба эдгээрээс дөрөвт нь (Чанартай боловсролыг дэмжих, Жендерийн эрх тэгш байдлыг хангах, Зохистой хөдөлмөр эрхлэлт ба эдийн засгийн өсөлтийг дэмжих, Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах) онцлон хувь нэмрээ оруулахаар тодорхойлсон билээ.

- Чанартай боловсролыг дэмжих
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах,
- Зохистой хөдөлмөр эрхлэлт ба эдийн засгийн өсөлтийг дэмжих
- Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах

2024 онд ХХБ анхны Тогтвортой хөгжлийн тайлангаа Sustainability Accounting Standards Board (SASB), Global Reporting Initiative (GRI) болон Монголын компаниудад зориулсан БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамж зэрэг дотоодын болон олон улсын тайлагналын тогтолцоо, стандартуудад уялдуулан гаргалаа. ХХБ нь тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд 2024 оны байдлаар нийт 1.8 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Банкны нийгмийн шинж чанартай зээлийн үлдэгдэл 2024 оны эцсийн байдлаар 1.8 их наяд хүрсэн ба ингэхдээ тус нийгмийн шинж чанартай зээлийн багцад орлогод нийцсэн орон сууц, нийгэм, эдийн засгийг дээшлүүлэлт, чадавхжуулалт, санхүүгийн үйлчилгээ, дэд бүтэц болон хүнсний аюулгүй байдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд хамгийн өндөр хувийг эзэлж байгаа юм.

Банкны ногоон зээлийн үлдэгдэл 2024 оны эцсийн байдлаар 113.5 тэрбум хүрсэн ба тус ногоон зээлийн багцад эрчим хүчний хэмнэлт, цэвэр тээвэр болон тогтвортой ус ба хог хаягдал ангиллын зээлүүд хамгийн өндөр хувийг эзэлж байгаа юм.

Тогтвортой хөгжлийн зорилтуудаас дараах дөрвөн зорилгыг ХХБ үйл ажиллагаандаа онцлон тусгаж хэрэгжүүлж байна.

ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ

Бид санхүүгийн боловсролыг түгээх, хуримтлалыг дадал болгох зорилгоор 2021 онд "Хуримтлалтай Монгол" хөтөлбөрөө санаачилсан билээ. Тус хөтөлбөрт 2024 онд нийт 653,946 харилцагч хамрагдаж, санхүүгийн мэдлэг боловсролоо нэмэгдүүлээд байна. Тус хөтөлбөр хэрэгжсэн 2021-2024 оны хугацаанд нийт 1,512 гаруй харилцагчийн хуримтлуулах дадлыг урамшуулсан байна.

653,946
Харилцагч хамрагдсан

1,512
Харилцагчийг урамшуулсан

ХЯЗГААРГҮЙ МОРООДОЛ

Бид 2018 оноос эхлэн хүүхэд, залууст оюуны хөрөнгө оруулалт хийх зорилготой Хязгаргүй мөрөөдөл төслөө эхлүүлсэн. Тус төсөл хэрэгжсэнээр 2024 оны байдлаар 58 сургуулийн номын санг тохижуулж, номын фондыг нь баяжуулж өгөөд байна. Энэхүү төслөөрөө дамжуулан нийт 200 мянга орчим хүүхэд залуус, 10,000 гаруй багш, сурган хүмүүжүүлэгчдийн боловсролд оюуны хөрөнгө оруулалт хийжээ. "Хязгаргүй мөрөөдөл" төслөө Дэлхийн аутизмын сарыг тохиолдуулан аутизмтай онцгой хүүхдүүдэд зориулан хэрэгжүүллээ. Бид цаашид ч Монгол Улсын хүүхэд бүр тэгш боломжоор хангагдаж, тэгш орчинд сурч боловсрох боломжийг бүрдүүлэхэд дэмжин ажиллах болно.

ХХБ нь 2024 онд шинэ ажилтнуудын 14 удаагийн сургалтад нийт 230 ажилтан, салбаруудад орох биечилсэн сургалтад 16 салбарын нийт 172 ажилтнуудыг хамруулж тогтвортой санхүүжилт, уур амьсгалын өөрчлөлт болон ХХБ-ны тогтвортой хөгжлийн чиглэлээрх стратегийн талаар суурь мэдээллийг хүргэлээ.

АНУ-ын "ABC" телевизийн уран бүтээл "Bet on Baby" шоу нэвтрүүлгийг албан ёсны эрхтэйгээр Монгол Улсад анх удаа NTV телевизээр дамжуулан хүргэсэн ба ХХБ нь "МААМУУ" хүүхдийн хадгаламжийн мэдээллийг хүргүүлэнгээ олон нийтэд санхүүгийн боловсрол олгох чиглэлд хамтран ажиллалаа.

Монгол Улсад анх удаа олон улсын хамгийн том боловсролын арга хэмжээ болох "STEAMEX 2024" зохион байгуулагдав. Тус арга хэмжээний үеэр бага ангийн болон байгалийн ухааны багш нарыг чадавхжуулах 100% практик туршилт, бүтээлд суурилсан хөтөлбөрт 21 аймаг бүрээс оролцох 100 багшийг санхүүжүүлэн оролцлоо.

ХХБ нь "VolgaCTF" дэлхийд нэр хүндтэй, ёс зүйт хакерын олон улсын CTF тэмцээнд Монгол Улсаас Мазаалай багаас шалгаран финалын шатанд өрсөлдсөн банкны ажилтнаа дэмжин оролцлоо. Энэхүү тэмцээнээс олж авсан туршлага нь ирээдүйд учирч болзошгүй халдлага, аюул заналаас урьдчилан сэргийлэх, халдлагад хариу арга хэмжээ авах, эмзэг байдлыг илрүүлэх, засварлах, мөн дүн шинжилгээ хийх ур чадварыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх боломжийг олгох юм.

ХХБ нь Даян дэлхийн ногоон хөгжлийн институттэй (GGGI) хамтран тогтвортой санхүүжилтийн хүрээнд хамтын ажиллагааны чиглэлд харилцан ойлголцлын санамж бичиг (MOU)-г 2024 оны 3-р сард байгуулж, хамтын ажиллагааны хүрээнд 10-12 саруудад дараах сургалтуудыг зохион байгуулсан байна.

Төвийн газар нэгж болон бүсийн төв, салбарын нийт 100 гаруй ажилтнуудад тогтвортой, ногоон санхүүжилтийн нийт 4 удаагийн сургалтыг ХНГ-тай хамтран амжилттай зохион байгуулав.

ЖДҮ эрхлэгчдэд зориулан бизнесээ ногооруулах, мэдлэг олгох зорилго бүхий сургалтыг томоохон харилцагч байгууллагуудын мэргэжилтнүүд ба экспертүүдтэй хамтран 2 цахим болон 3 удаагийн танхимаар зохион байгуулж, ББГ, ЖДББГ болон салбар, тооцооны төвүүдэд сургалтын урилгын хүргүүлж, нийт 80 гаруй харилцагчдыг хамруулж ажиллав.

ХХБ болон Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-н хамтарсан Монгол улс дах жижиг дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, тогтвортой санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах төслийн хүрээнд:

ЖДББГ-тай GIZ байгууллагын гэрээт зөвлөх үйлчилгээний байгууллагуудын хамтаар давтагдсан тоогоор нийт 80 гаруй ЖДББГ сегмент болон Дархан, Эрдэнэт салбарын харилцагч нарт эхний багц сургалтыг амжилттай зохион байгуулав.

GIZ байгууллагын гэрээт зөвлөх Содура консалтинг ХХК хамтран нийт 20 бүсийн болон салбарын захирлуудад, ЖДББГ сегментийн 18 харилцааны менежерт нарт сургалт зохион байгуулав.

- Монгол Улсын Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгчдийн холбооны хүсэлтийн дагуу "Олон улсын шинэ эрчим хүчний чуулган 2024" арга хэмжээний панелд ХХБ-с Ногоон банк болох урт хугацааны зорилтын талаарх мэдээллийг хүргэн, оролцлоо.
- Каритас Чех Репаблик ТББ-с ирүүлсэн хүсэлтийн дагуу ЖДҮ эрхлэгч нарт зориулж зохион байгуулсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд "Ногоон зээлийн шалгуур үзүүлэлт"-ийн талаар сургалт оров.
- Монголын Үл хөдлөх хөрөнгө удирдлагын академийн "НОГООН РЕАЛТОР БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨР"-ийн дагуу ХХБ-с "Ногоон санхүүжилт" болон "Ногоон зээлийн шалгуур үзүүлэлт"-ийн талаарх сургалтуудыг орлоо.
- Мөн энэ онд ХХБ нь сар бүрийн ToC мэргэжлийн зөвлөлүүдийн уулзалт болон холбооноос зохион байгуулдаг мэдлэг түгээх хэлэлцүүлэг, семинаруудад хамрагдлаа.
- НҮБ-ын аж үйлдвэр хөгжлийн байгууллагаас санаачилсан эмзэг бүлгийн өрх толгойлсон эмэгтэйчүүдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох сургалтыг ХХБ-аас амжилттай зохион байгуулав. Тус сургалтын хүрээнд эмэгтэйчүүдэд санал болгож буй зээлийн бүтээгдэхүүний талаар мэдээлэл олгосноос гадна өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжууд, санхүүгийн зохицуулалт хийх ур чадваруud, санхүүгийн хуримтлал үүсгэх арга зам болон зээлийн зөв зохистой хэрэглээ зэргээр сургалт орсон байна.

ТАСРАЛТГҮЙ СУРАЛЦАГЧ

ХХБ нь "Тасралтгүй суралцагч" үндсэн зорилгын хүрээнд 2024 онд банкны нийт ажилтнуудаа 1,955.9 цагийн 499 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт давхардаагүй тоогоор 2,449 ажилтан хамрагдсан бөгөөд нэг ажилтан дунджаар 8-9 удаагийн сургалтад хамрагдсан ба ингэхдээ нэг ажилтанд ногдох сургалтын цаг 0.8 цаг байна.

Удирдах ажилтнуудад чиглэсэн дараах 2 хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлсэн. Үүнд:

ХХБ-ны залгамж халаа бэлтгэх зорилгын хүрээнд "Future Leaders" хөтөлбөрийг санаачлан салбарын захирал бэлтгэж 4 үе шаттай зохион байгуулсан. Нээлттэй 2 удаагийн сонгон шалгаруулалтад тэнцсэн 16 ажилтанд манлайллын 10 модуль сургалтыг амжилттай зохион байгуулж, сургалт бүр богино хэмжээний даалгавар өгч ажиллуулсан. Сургалтын дараа сүүлийн шатны сонгон шалгаруулалт хийж, ажилтны карьер хөгжлийг дэмжин ажиллалаа.

ХХБ нь 2024 онд 2 удаагийн ментор хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

ХХБ-ны "Lady's leadership" хөтөлбөрийн хүрээнд эмэгтэй ажилтнуудын карьер хөгжлийг дэмжих, тэдний манлайллын чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 3 удаагийн модуль сургалт болон менторын 3 сарын хөтөлбөр хэрэгжүүлэн ажилласан.
Банкны хэмжээнд ментор хөтөлбөр хэрэгжүүлэн нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулан, 10 ментий болон 10 ментор бүхий хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна.

ХХБ-ны 2024 оны шинээр томилогдон ажиллаж буй газар, хэлтэс, салбарын захирлуудад зориулсан "Манлайлал, удирдах арга барилын сургалт"-ыг зохион байгуулж, манлайллын ур чадварыг нэмэгдүүлж, хөгжүүлэх зорилгоор 3 удаагийн мэргэжлийн байгууллагын сургалт зохион байгуулсан. ХХБ нь ажилтнуудын тасралтгүй суралцагч байх стратегийн зорилгыг дэмжих зорилгоор UDEMY олон улсын платформтой 4 дэх жилдээ хамтран ажиллаж байна. Ажилтнууд өөрийн ур чадварыг хөгжүүлэх зорилгоор нийт 80,000+ гаруй сургалтыг нээлттэй үзэх боломжийг бүрдүүлж өгсөн. Удирдах ажилтнууд улирал бүр стратегийн зорилт бүхий сургалтад хамрагдаж байна.

ХХБ-ны зээл хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах хөтөлбөрийн хүрээнд "Көүчинг 2024" хөтөлбөр хэрэгжүүлэн ажилласан. Шинээр томилогдон ажиллаж байгаа ажилтнуудыг туршлагатай көүчий нартай хамтран сургалт, дадлагажуулан ажиллах зэрэг нэгдсэн хөтөлбөр боловсруулан амжилттай хэрэгжүүлсэн. Көүчинг хөтөлбөрт нийт 8 көүч, 16 көүчий амжилттай хамрагдаж байна.ХХБ-ны залгамж халааг бэлтгэх бодлогын хүрээнд харилцааны менежер ажлын байранд бэлтгэх, банкны зээлийн үйл ажиллагаа болон зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг таниулан сургах зорилгоор 2 удаа хэрэгжүүлэв. Үүнд нийт 2 удаагийн сургалтад 31 ажилтан хамрагдсан байна.

ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ

ХХБ нь 2019 онд бүрэн шинэчлэгдсэн "Жендерийн эрх тэгш байдлын бодлого"-г олон улсын стандартад нийцүүлэн баталж, банкны жендерийн эрх тэгш байдлын үйл ажиллагааг хангах Жендерийн Хороог байгуулж, байгууллагын бүхий л түвшинд Жендерийн эрх тэгш байдлын бодлогын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ХХБ нь үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах замаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үр дүнтэй оролцоог жендерийн мэдрэмжтэйгээр дэмжихэд хувь нэмэр оруулсаар байгаа билээ.

Жендерийн тэгш байдлыг хангах бодлогын хүрээнд ажлын байрны аюулгүй орчныг бүрдүүлэхийн тулд ХХБ нь өөрийн дотооддоо "ХХБ-ны ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам"-аа батлан гаргасан ба 2024 оноос эхлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж ажлын байран дээрх бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамт үйлдэгдсэн тохиолдлыг шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх механизмыг бий болгон мөрдөн ажиллаж байна.

ХХБ нь 2024 оноос ажилтнууддаа уян хатан цагаар ажиллах боломжоор хангаснаар Нярайн чөлөөтэй ажилтнууддаа зориулсан уян хатан цагаар, зайнаас ажиллах боломжтой ажлын байрыг санал болгож эмэгтэй ажилтнуудын тасралтгүй хөгжил, карьерын тогтвортой байдлыг хангах зорилготой тус хөтөлбөрийг 2023 оны 11 сараас зарлан 2024 оноос амжилттай хэрэгжүүлж байна.

Жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэй харилцагч нарт зориулан BE LADY форум, нетворкинг арга хэмжээг 2024 оны 5-р сард хэлэлцүүлэг бүхий форум арга хэмжээг зохион байгуулсан ба тус арга хэмжээний нь ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор санал болгож буй тогтвортой санхүүжилтийн чиглэлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулах, үндэсний сайн жишээг таниулах, олон улсын сайн туршлагаас суралцах, хамтын ажиллагааг бэхжүүлэх ач холбогдол бүхий үйл ажиллагаа болсон юм.

Худалдаа, хөгжлийн банк нь Америкийн элчин сайдын яамтай хамтран эмэгтэй бизнес эрхлэгч нарт зориулсан санхүүгийн мэдлэг олгох арга хэмжээг амжилттай зохион байгуулласа. Тус арга хэмжээний үеэр "Эмэгтэй энтерпренерүүдийн академи" хөтөлбөрийн танилцуулга, эмэгтэй энтерпренерүүдийн амжилтын түүх, ХХБ-ны санхүүгийн хөтөлбөрүүд болон бизнесийн стратеги, түүний ач холбогдлыг таниулах практик сургалт боллоо.

ХХБ-ны ууган салбаруудын нэг болох Эрдэнэт салбарын үүсгэн байгуулагдсаны түүхт 25 жилийн ой 2024 онд тохиосон байна. Ойн баяраараа тус банкны салбар эх үрсийн эрүүл мэндийг дэмжих, эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор "Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төв"-д нярайн шарлагын аппарат бэлэглэлээ.

ХХБ-ны нийт ажилтнууд 2024 оны эцсийн байдлаар 64 хувь нь эмэгтэй, 36 хувь нь эрэгтэй байна. Түүнчлэн Банкны дунд түвшний ажилтнуудын 49 хувь нь эмэгтэй, 51 хувь нь эрэгтэй байна.

ХХБ нь 2024 оны эцсийн байдлаар томоохон харилцагч байгууллагуудын гүйцэтгэх захирлуудын 34 хувь нь эмэгтэй, 66 хувь нь эрэгтэй байхад жижиг, дунд бизнесийн сегментийн харилцагчдын гүйцэтгэх захирлуудын 51 хувь нь эмэгтэй, 49 хувь нь эрэгтэй байна. Түүнчлэн, ХХБ-аас бизнесийн зээлийн бүтээгдэхүүн олгосон иргэдийн 55 хувь нь эмэгтэй, 45 хувь нь эрэгтэй байгаа бол банкнаас иргэдийн зээлийн бүтээгдэхүүн олгосон иргэдийн 56 хувь нь эмэгтэй, 44 хувь нь эрэгтэй байна.

ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ

ХХБ-ны алсын хараа нь хувьцаа эзэмшигчдэдээ үнэ цэнийг бий болгож, олон улсын стандарт нийцсэн банкны үйлчилгээ, бүтээгдэхүүн харилцагчдадаа санал болгодог МУ-ын тэргүүлэгч арилжааны банк байх юм. Банкны эрхэм зорилго бол уламжлалт болон дижитал хэлбэрээр харилцагчидтай ойр байж хэрэгцээ шаардлагыг ойлгож, тэдгээрийг хангахад туслах юм. Түүнчлэн, ХХБ нь 2050 он гэхэд Ногоон банк болох урт хугацааны зорилгын хүрээнд 2030 он гэхэд 2 тэрбум ам. долларын санхүүжилтийг харилцагчдадаа олгох, мөн бизнесийн болон дотоод үйл ажиллагааг ногоон эдийн засгийн загварт нийцүүлэх зэрэг хэтийн зорилгуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна.

Тухайлбал, 2024 оны байдлаар ХХБ нь бусад арилжааны банкнуудтай харьцуулахад өөрийн хөрөнгийн хэмжээ, нийт зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээ зэргээр гурав дугаарт, нийт хадгаламжийн хэмжээгээр гурав дугаарт эрэмбэлэгдэж байна. Мөн, ХХБ нь МУ-ын бараг бүх томоохон салбар дахь 7,600 орчим аж ахуй нэгжид үйлчилгээ үзүүлдэг ба тайлант хугацаанд Япон улсын Токио дахь төлөөлөгчийн газрыг оруулаад нийт 90 салбар, тооцооны төв, 264 бэлэн мөнгөний ATM болон 15,290 POC терминалаар дамжуулан үйл ажиллагаа явуулж байна.

90
Салбар тооцооны төв

264
Бэлэн мөнгөний ATM

15,290
POC терминал

Түүнчлэн, 2024 оны байдлаар ХХБ-ны нийт 840 томоохон харилцагч байгууллагын зээлийн үлдэгдэл ойролцоогоор нийт 3,162.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. ХХБ-ны нийт 1,991 жижиг болон дунд бизнес сегментийн харилцагч байгууллагын зээлийн үлдэгдэл нийт ойролцоогоор 817.8 тэрбум төгрөгт хүрсэн ба өмнөх оны тус сегментийн зээлийн багцтай мөн харьцуулахад 65.1 хувиар өсжээ. Мөн ХХБ-ны нийт 119,399 иргэн харилцагчийн зээлийн үлдэгдэл ойролцоогоор 2.3 их наяд төгрөгт хүрсэн ба иргэдийн зээлийн багц өмнөх онтой мөн харьцуулахад 35.9 хувиар өссөн байна.

ХХБ нь 2020 оноос хойш иргэдэд зориулсан хэрэглээний ногоон зээлийн бүтээгдэхүүнийг өөрсдийн эх үүсвэрээр гаргаж эхэлсэн ба 2024 оны байдлаар ХХБ-ны ногоон зээлийн багц нийт 113.5 тэрбум төгрөг байсан. Мөн 2024 оны байдлаар ХХБ-ны нийгмийн шинж чанартай зээлийн хэмжээ 1.8 их наяд төгрөг байсан ба энэ нь нийт банкны зээлийн багцаас 27.1 хувийг эзэлжээ.

ХХБ нь 2023 оны 5 дугаар сард IPO буюу 5% хүртэлх хувьцааг анхдагч зах зээлд арилжаалж, үүний үр дүнд нийт 2,528 хөрөнгө оруулагчдаас 105.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий захиалга хүлээн авч, татан төвлөрүүлэх зорилтот дүн болох 83.5 тэрбум төгрөгийн захиалга 126.4% гүйцэтгэлтэйгээр амжилттай хаагдсан байна. Тус эх үүсвэрийн зарцуулалт 2024 онд амжилттай зарцуулагдаж дуусан ба тус татан төвлөрүүлсэн хөрөнгийг өөрийн "Ногоон банк" болох урт хугацааны зорилгын хүрээнд ХХБ-ны "Тогтвортой санхүүжилтийн хүрээ" баримт бичигт тусгагдсан ногоон болон нийгмийн зээлийн ангиллуудад уялдуулан санхүүжилт олгосон байна.



Уламжлал болсон худалдааны санхүүжилтийн форумыг зохион байгуулсан ба худалдаа, үйлчилгээний бизнесийн орчныг шинээр харж, сорилт бэрхшээл, ололт амжилт, шинэ боломжийг харилцагчид болон бизнесийн итгэлт түншүүдтэйгээ хамт хэлэлцлээ.

Монгол Улс болон Европын улс орнуудын хооронд дахь бизнес харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд Европ - Монголын хамтарсан Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас зохион байгуулсан "Global Gateway project - Opportunities for companies in Mongolia" арга хэмжээнд Platinum Sponsor-р оролцлоо.

ХХБ нь Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй олон улсын байгууллагууд болон элчин сайдын яамуудтай өргөн хүрээний харилцаа, хамтын ажиллагаатай ажилладаг ба үүний хүрээнд бид Франц - Монгол хоёр орны хооронд бизнес эрхэлдэг бизнес эрхлэгч нартаа зориулсан VIP хүлээн авалтаа зохион байгуулаа.

"Welcome to Mongolia" уриатай "Монголын эдийн засгийн форум 2024" арга хэмжээг дэмжин ажиллав. Форумын үеэр тогтвортой санхүүжилтийн чиглэлийн ажлуудыг онцлон дурдав.

ХХБ-ны хамт олон дэлхийн банк, санхүүгийн арга хэмжээ болох "Sibos-2024" баг хамт олноороо амжилттай оролцож Монгол Улсын банк санхүүгийн түүх, ололт амжилт, үйл ажиллагааг таниулан сурталчиллаа. Түүнчлэн, шинэлэг санал санаачлага, стратеги зорилтуудын талаар туршилга солилцлоо.

ХХБ нь Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ, Зээлийн батлан даалтын сантай хамтран Улаанбаатар хотын ЖДҮ эрхлэгч нарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэхээр боллоо. ХХБ нь тус хөтөлбөрөөр дамжуулан жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгынхоо хүрээнд бодит хэрэгцээ шаардлага бүхий ЖДҮ эрхлэгч нарт хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл олгоно. Ингэснээр бизнес эрхлэгчдийн зах зээлд өрсөлдөх чадвар, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх, салбарын хэмжээнд улсаас хэрэгжүүлж буй бодлогод хувь нэмэр оруулан дэмжлэг үзүүлэх том алхам болох юм.

Bloomberg TV Mongolia 2013 оноос эхлэн жил бүр Монгол Улсын эдийн засгийн өсөлт, хөгжил дэвшилд томоохон хувь нэмэр болсон хамгийн шилдэг бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, бодлого шийдлийг "Bloomberg Awards"-т нэр дэвшүүлэн манлайлагчдыг тодруулж ирсэн билээ. Энэ жилийн хувьд тус санаачилгын дараагийн хуудсыг нээж, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн "хурдасгуур" болж буй шилдгүүд буюу "Catalyst"-уудыг тодрууллаа. Арга хэмжээний ерөнхий ивээн тэтгэгчээр ХХБ ажиллалаа.

НҮБ-ын суурь конвенцын Талуудын 29 дүгээр бага хуралд (COP29) -д ХХБ-ны ТУЗ-ийн дарга Р.Коппа оролцсон ба тус хурал нь Дэлхийн хүлэмжийн хийн ялгарлыг 2050 он гэхэд тэглэх, дэлхийн дулааралыг 1.5 хэмд тогтоон барих улс орнуудын Парисын хэлэлцээрийн үүрэг хариуцлагын биелэлтийг хангуулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, санхүүжилт татан, хөгжиж буй орнуудын хэрэгцээ шаардлагыг хангах, ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилготой юм.

Монгол Улс дахь Америкийн худалдааны танхим Am-Cham Mongolia-с зохион байгуулдаг хамгийн том арга хэмжээ болох "CSR AWARDS 2024"-н цорын ганц "Diamond" спонсороор ХХБ ажиллаа. Арга хэмжээний үндсэн зорилго нь оны ололт амжилтуудаа бататган дүгнэх, хоёр улсын хоорондын бизнесийн орчныг сайжруулж, нийгмийн ач холбогдлыг сурталчилж, өндөр түвшний харилцан хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой билээ.

ХХБ нь 2030 он гэхэд хоёр тэрбум ам. долларын тогтвортой санхүүжилтийг харилцагчдадаа хүргэх урт хугацааны зорилт дэвшүүлсэн ба энэхүү зорилтын хүрээнд 2024 оны 10-р сард АНУ-ын Засгийн газрын агентлагийн Хөгжлийн Санхүүгийн Корпорац (DFC)-с анхны санхүүжилтээ амжилттай татсан ба тус санхүүжилт нь Монголын ЖДҮ болон эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжсэн жижиг дунд үйлдвэрлэгчид мөн ногоон, тогтвортой бизнесийг дэмжих зорилготой юм. Тэргүүлэгч банкны хувьд улс орны эдийн засгийг солонгоруулах, ажлын байр бий болгох зорилгоор ЖДҮ-ийн зах зээлийг эзлэх хувийг нэмэгдүүлэн ажиллаж байна. Мөн ХХБ нь 10-р сард Монгол Улсад анх удаа олон улсын зах зээлд нийт 50 сая ам.долларын ногоон болон нийгмийн бонд гаргасан. Тус бондыг ХХБ-ны Тогтвортой байдлын хүрээний дагуу ногоон болон нийгмийн зээлийн шалгуурт нийцсэн зээлийг санхүүжүүлэхэд зарцуулна.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БАГАСГАХ

ХХБ нь Монголын тогтвортой санхүүгийн холбоотой хамтран Уур амьсгалын ногоон сан (УАНС)-гийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй "Монгол Улсад тогтвортой болон ногоон санхүүжилтийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх Бэлэн байдлын хөтөлбөр"-ийг амжилттай хэрэгжүүлж дууслаа.

ХХБ нь орон нутгийн ногоон хөгжлийг дэмжих, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилго бүхий "Монгол Улс дахь бүс нутгийн ногоон дэд бүтцийг хөгжүүлэх" бэлэн байдлын төслийг Уур амьсгалын ногоон сангаар амжилттай батлуулан, хэрэгжүүлж дуусгав. Тус бэлэн байдлын төслийн үр дүнг олон талт оролцогчдод танилцуулах зорилгоор 12-р сарын 10-ны өдөр "Оролцогч талуудын хэлэлцүүлэг"- ийг зохион байгуулсан байна.
Share issue	17,042,650	66,448,901	–	–	83,491,551
Transaction costs related to issuance of new shares	–	(2,379,860)	–	–	(2,379,860)
Transfer	(74)	74	–	–	–
At 31 December 2023 and 1 January 2024	**340,852,905**	**64,069,779**	**313,673,176**	**689,783,035**	**1,408,378,895**
Profit for the year	–	–	–	298,635,619	298,635,619
Other comprehensive income	–	–	9,451,129	–	9,451,129
Total comprehensive income	**–**	**–**	**9,451,129**	**298,635,619**	**308,086,748**
Realised revaluation reserve	**–**	**–**	(4,176,217)	4,176,217	–
Revaluation of asset transfered to investment properties (Note 29)	**–**	**–**	4,061,458	–	4,061,458
Dividend (Note 30)	**–**	**–**	–	(104,541,514)	(104,541,514)
Movement on regulatory reserve*	**–**	**–**	(5,380,016)	5,380,016	–
At 31 December 2024	**340,852,905**	**64,069,779**	**317,629,530**	**893,433,373**	**1,615,985,587**

*Reserves include the regulatory reserve that is set up in compliance with Bank of Mongolia ("BoM") requirements and is distributable to Shareholders of the Bank subject to BoM's approval.

The accompanying notes form an integral part of the financial statements.

TRADE AND DEVELOPMENT BANK OF MONGOLIA JSC

Statement of cash flows

For the year ended 31 December 2024

	Notes	2024 MNT'000	2023 MNT'000
CASH FLOWS FROM OPERATING ACTIVITIES			
Profit before tax		388,205,863	196,806,181
Adjustments for:			
Changes in fair value of financial derivatives	**7**	(13,881,202)	2,719,591
Loss/(gain) on disposal of property and equipment	**7**	5,306,473	(21,290)
(Gain)/Loss on disposal of assets-held-for sale, net	**7**	(158,782)	8,831
Valuation gain on investment property	**7**	(3,053,461)	(2,873,791)
(Gain)/Loss on disposal of foreclosed properties, net	**7**	(1,061,392)	(2,097,115)
Gain on disposal of investment properties	**7**	–	(385,314)
(Gain)/Loss on disposal of debt instrument measured at FVOCI	**7**	(620,874)	69,385
Fair value (gain)/loss on other loans receivables	**7**	(7,630,492)	8,311,181
Amortisation of deferred grant	**7**	(748,866)	(203,242)
Share of profit in associate	**15**	5,031,979	(4,271,538)
Credit loss expense	**8**	22,633,058	35,419,047
Depreciation of property and equipment	**9**	17,364,478	14,180,303
Amortisation of intangible assets	**9**	1,092,379	920,110
Depreciation of rights-of-use assets	**9**	7,386,391	6,782,507
Property and equipment written off	**9**	1,403,605	110,214
Intangible assets written off	**9**	967	1,809
Interest expense of borrowed funds	**5**	61,057,810	78,350,667
Interest expense of debt securities issued	**5**	4,200,696	–
Accretion of interest on lease liabilities	**5**	1,802,903	2,050,311
Unrealised foreign exchange difference		(81,232,686)	34,187,679
Operating profit before working capital changes		**407,098,847**	**370,065,526**
Changes in operating assets and liabilities:			
Statutory deposits with BoM		(129,587,811)	(201,639,684)
Due from other banks and financial institutions		(100,728,870)	185,324,854
Loans and advances to customers		(1,262,677,013)	(808,036,358)
Assets-held-for sale		(95,580,872)	(6,592,824)
Other assets		(52,433,613)	(78,573,913)
Due to banks		60,448,995	285,291,777
Repurchase agreements		(25,609,640)	(265,519,739)
Due to customers		1,336,250,669	2,909,901,740
Other liabilities		(100,407,322)	(102,875,012)
Cash generated from operations		**36,773,370**	**2,287,346,367**
Interest portion of the lease liabilities paid		(1,802,903)	(2,050,311)
Interest paid on borrowed funds		(91,648,527)	(48,603,736)
Interest paid on debt securities issued		–	–
Income tax paid		(85,257,310)	(30,393,733)
Net cash flows generated from operating activities		**(141,935,370)**	**2,206,298,587**

The accompanying notes form an integral part of the financial statements.

TRADE AND DEVELOPMENT BANK OF MONGOLIA JSC

Statement of cash flows (cont'd.)

For the year ended 31 December 2024

	Notes	2024 MNT'000	2023 MNT'000
CASH FLOWS FROM INVESTING ACTIVITIES			
Purchase of financial investments		(838,105,697)	(380,367,125)
Proceeds from disposal of financial investments		361,715,278	844,281,732
Proceeds from financial derivatives		5,908,554	81,431,276
Proceeds from disposal of property and equipment		5,916,741	3,943,285
Proceeds from dividend received	**14**	221,276	194,694
Purchase of property and equipment	**21**	(28,574,973)	(74,749,691)
Purchase of intangible assets	**23**	(23,404,029)	(1,968,076)
Net cash flows (used in)/generated from investing activities		**(516,322,850)**	**472,766,095**
CASH FLOWS FROM FINANCING ACTIVITIES			
Proceeds from drawdown of borrowed funds		3,758,252,939	342,417,862
Repayment of borrowed funds		(2,849,988,893)	(952,421,711)
Proceeds from issuance of debt securities		843,472,451	–
Repurchase of debt securities	**28**	(168,706,103)	–
Payment of deferred upfront fees		(13,368,143)	(94,179)
Dividend paid	**30**	(104,129,269)	(47,198,750)
Proceeds from grant received	**29**	307,720	613,771
Proceeds from issuance of shares	**30**	–	81,111,691
Payment of principal portion of lease liabilities		(7,084,674)	(6,180,280)
Net cash flows generated from/(used in) financing activities		**1,458,756,028**	**(581,751,596)**
Net increase in cash and cash equivalents		**800,497,808**	**2,097,313,086**
Cash and cash equivalents brought forward	**12**	4,212,696,578	2,115,383,492
Cash and cash equivalents carried forward	**12**	**5,013,194,386**	**4,212,696,578**
OPERATIONAL CASH FLOWS FROM INTEREST			
Interest paid		(585,204,954)	(419,723,524)
Interest received		1,069,500,834	738,867,664
NON-CASH ACTIVITIES			
Additions to right-of-use assets and lease liabilities	**22**	282,280	2,562,951
Modification of leases	**22**	2,581,034	2,020,078
Foreclosure of collaterals		106,732,257	8,697,682
Additions to property and equipment	**21**	–	63,652,848
Consideration for disposal of investment property		–	(29,614,685)

Reconciliation of changes in liabilities arising from financing activities:

Lease liabilities	2024 MNT'000	2023 MNT'000
At 1 January	13,870,478	15,869,783
Non-cash additions	282,280	2,562,951
Lease modification	2,581,034	2,020,078
Termination of lease	(104,435)	(402,054)
Interest expense during the year	1,802,903	2,050,311
Interest portion of the lease liabilities paid	(1,802,903)	(2,050,311)
Principal portion of lease liabilities paid	(7,084,674)	(6,180,280)
At 31 December	**9,544,683**	**13,870,478**

The accompanying notes form an integral part of the financial statements.

Reconciliation of changes in liabilities arising from financing activities (cont'd.):

	Borrowed funds MNT'000	Debt securities issued MNT'000
At 1 January 2023	**1,418,831,195**	**–**
New disbursement	342,417,862	–
Repayment	(952,421,711)	–
Interest repayment	(48,603,736)	–
Deferred upfront fee	(94,179)	–
Net repayment	(658,701,764)	–
Foreign exchange movement	34,187,679	–
Non-cash items arising from financing activities	34,187,679	–
Interest expense accrued and deferral amortisation	78,350,667	–
At 31 December 2023 and 1 January 2024	**872,667,777**	**–**
New disbursement	3,758,252,939	843,472,451
Repayment	(2,849,988,893)	–
Repurchase of debt securities	–	(168,706,103)
Interest repayment	(91,648,527)	–
Deferred upfront fee	(5,482,656)	(7,885,487)
Net repayment	811,132,863	666,880,861
Foreign exchange movement	(80,721,085)	(511,601)
Non-cash items arising from financing activities	(80,721,085)	(511,601)
Interest expense accrued and deferral amortisation	61,057,810	4,200,696
At 31 December 2024	**1,664,137,365**	**670,569,956**

Дэлгэрэнгүй тайлан: https://www.tdbm.mn/sites/default/files/2025-04/24%20FS.02%20TDBM%20AFS%20MON%20signed.pdf

The accompanying notes form an integral part of the financial statements.

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ**

Монголын банкны салбар 2024 онд өмнөх оны томоохон өөрчлөлт, шинэчлэлтүүдийн үр нөлөөг бататган, цаашдын тогтвортой хөгжлийн суурийг бэхжүүлэхэд анхаарсан жил байлаа. Худалдаа, хөгжлийн банк (ХХБ) нь нээлттэй хувьцаат компани болсон статусаа ашиглан, засаглал, ил тод байдлаа улам сайжруулж, зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг идэвхтэй явуулсаар байна. Банкны салбар ерөнхийдөө өсөлтөө хадгалахын зэрэгцээ, дижитал шилжилт, эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох зэрэгт түлхүү анхаарсан нь 2024 оны онцлог байв.

ХХБ нь нээлттэй хувьцаат компани болсноор бэхэжсэн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн бүрэлдэхүүн 2024 онд банкны стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэв. Өргөтгөсөн, олон талт ур чадвартай ТУЗ нь банкны бизнесийн тасралтгүй өсөлтийг дэмжих, эрсдэлийн удирдлагын оновчтой тогтолцоог хэвшүүлэх, дотоодын болон олон улсын шилдэг туршлага, стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд чиглэсэн стратегийн удирдамж, зөвлөмжөөр тогтмол хангаж ажиллалаа. ТУЗ нь 2024 оны турш Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Банкны зохистой засаглалын зарчмууд болон ХХБ-ны дүрмийг үйл ажиллагааныхаа үндэс болгон, ТУЗ болон түүний дэргэдэх хороодын тогтоол, шийдвэрээр дамжуулан банкны үйл ажиллагааг чиглүүлж, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын эрх ашгийг дээдлэн, тэдний үнэ цэнийг өсгөхөд онцгой анхаарал хандуулав.

Банкны 2024 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлт нь ХХБ-ны урт болон дунд хугацааны стратегийн хэрэгжилт, тухайн жилийн батлагдсан санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд ТУЗ-ийн гишүүдийн хийсэн хараат бус, бодит үнэлгээнд суурилсан болно.

2024 онд ХХБ-ны Гүйцэтгэх удирдлагын баг болон нийт ажилтнууд ТУЗ-өөс баталсан стратегийн чиглэлийн дагуу банкны урт хугацааны зорилтууд болох:

- Харилцагч төвтэй байдлаа улам гүнзгийрүүлэх,
- Олон улсын зах зээл дэх байр сууриа бэхжүүлэх,
- Технологийн дэвшилд суурилсан, шинэлэг үйлчилгээ бүхий платформ банк болох алсын хараг хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллалаа. Эдгээр хүчин чармайлтын үр дүнд банкны актив, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, зах зээлд эзлэх байр сууриа бэхжүүлэх чиглэлээр төлөвлөгөөт зорилтуудыг ханган биелүүлэхээр хичээнгүйлэн ажилласан гэдэгт итгэлтэй байна.

2024 он нь стратегийн зорилтуудаа амжилттай ахиулж, зах зээл дэх манлайлал, олон улсын тавцан дахь нэр хүндээ улам бататган, инноваци, тогтвортой хөгжлийн чиглэлээр бодитой үр дүнд хүрсэн онцгой жил байлаа. Банкны урт хугацааны стратегийн гурван тулгуур чиглэлийн хүрээнд Гүйцэтгэх удирдлага болон нийт ажилтнуудын хүчин чармайлтаар 2024 онд дараах томоохон амжилтад хамтын хүчээр бид хүрлээ.

ХАРИЛЦАГЧ ТӨВТЭЙ БАНК БОЛОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Банкны бүх үйл ажиллагааны төвд харилцагчийг тавьж, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн, орчин үеийн, хүртээмжтэй, найдвартай үйлчилгээг хүргэхэд онцгой анхаарал хандуулж, харилцагчийн туршлагыг тасралтгүй сайжруулж, ажиллалаа. Харилцагчдадаа дэлхийн жишигт нийцсэн, хялбар, аюулгүй төлбөрийн шийдлийг санал болгох зорилгоор ApplePay үйлчилгээг Монгол Улсад анхлан амжилттай нэвтрүүлж, дижитал төлбөр тооцооны шинэ боломжийг нээлээ. Харилцагчийн картын болон хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг олон улсын дээд түвшний стандартад нийцүүлэн ажиллаж байна. Харилцагчдад үйлчлүүлэх таатай, орчин үеийн орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор үндэсний шилдэг компаниудын нэг A1 Architects-тэй хамтран банкны салбаруудын дотоод интерьер, тохижилтыг шинэчлэх ажлыг эхлүүлж, үйлчилгээний чанарт бодит хөрөнгө оруулалт хийлээ.

ОЛОН УЛСЫН БАНК БОЛОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

ХХБ нь олон улсын санхүүгийн зах зээлд Монгол Улсын болон өөрийн банкны нэр хүндийг өсгөх, дэлхийн жишигт нийцсэн үйл ажиллагаа явуулах, гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх чиглэлээр 2024 онд томоохон алхмуудыг хийлээ. АНУ-ын Bank of New York Mellon-той тогтоосон ам.долларын ностро дансны харилцаагаа бататгаж, Монгол Улсыг дэлхийн ам.долларын төлбөрийн системд найдвартай, тасралтгүй холбох үүргээ амжилттай гүйцэтгэв. Түүхэн амжилт болгож, Монголын банк санхүүгийн байгууллагаас анх удаа АНУ-ын Засгийн газрын агентлаг болох Олон Улсын Хөгжлийн Санхүүжилтийн Корпорац (DFC)-аас шууд урт хугацааны санхүүжилт татсан нь Монгол Улсын бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, эмэгтэй бизнес эрхлэгчдийн өсөлт болон уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулах чухал эх үүсвэр болов. Мөн Австри Улсын Венийн хөрөнгийн бирж дээр олон улсын мэргэжлийн хөрөнгө оруулагчдад зориулан Монгол Улсаас анх удаа Нийгмийн болон Ногоон бондыг амжилттай гаргаж, дэлхийн топ 10-т багтдаг Ассет Менежмент компаниас хөрөнгө оруулалт татсан нь олон улсын тогтвортой санхүүжилтийн зах зээлд нэвтрэх шинэ гарцыг нээлээ. Эдгээр амжилтууд нь банкны санхүүгийн тогтвортой байдал, зөв засаглалын илрэл болж, олон улсын зэрэглэл тогтоогч Moody's агентлагаас ХХБ-ны зээлжих зэрэглэлийг B2 “Тогтвортой” түвшинд ахиулахад эерэгээр нөлөөлөв.

ПЛАТФОРМ БАНК БОЛОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа үр дүнтэй нэвтрүүлж, банкны үйлчилгээний хүртээмж, үр ашиг, найдвартай байдлыг нэмэгдүүлэхэд чухал ахиц дэвшил гаргалаа. Төлбөрийн картын аюулгүй байдлын олон улсын PCI DSS 4.0 стандартыг амжилттай хангаж, 8 дахь жилдээ харилцагчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Банкны үйлчилгээг газарзүйн байршлаас үл хамааран хүргэх, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Агент банкны үйлчилгээг амжилттай нэвтрүүлж, банкны үйлчилгээг иргэдэд илүү ойртуулсан шинэлэг сувгийг бий болгов. Харилцагч, олон нийтэд зориулсан мэдээллийн гол суваг болох банкны вебсайтыг Канад улсын Image X компанитай хамтран орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилж, дижитал орчин дахь хэрэглэгчийн туршлагыг сайжруулав.

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА ХАМТЫН ҮНЭ ЦЭН БҮТЭЭХ:

ХХБ нь тогтвортой хөгжлийн зорилтуудыг үйл ажиллагаандаа тууштай хэрэгжүүлж, эдийн засгийн тулгуур хүч болсон жижиг, дунд бизнес (ЖДБ)-ийг идэвхтэй дэмжлээ. Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-тэй хамтран ЖДБ-ийг дэмжих "SFME" төслийг хэрэгжүүлэх гэрээ байгуулж, Дижитал Кредит ХХК-тай хамтын ажиллагаа эхлүүлэв. Түүнчлэн, Ханбогдын Хөгжлийн Хурдасгуур Оюу Толгойн сан, Даян дэлхийн ногоон хөгжлийн институт (GGGI), Нийслэлийн ЖДҮҮ-г Дэмжих Төв, Зээлийн Батлан Даалтын Сан зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг, гэрээ хэлэлцээрүүдийг байгуулж, бүс нутгийн ногоон хөгжил, ЖДБ-ийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал алхмууд хийлээ. Анх удаа эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан "BE LADY" форумыг амжилттай зохион байгуулж, жендэрийн тэгш байдлыг дэмжих чиглэлээр хийсэн ажлуудаараа Тогтвортой Санхүүжилтийн Холбооноос "Жендерийн Манлай Байгууллага"-аар шалгарав. Мөн уламжлал болгон зохион байгуулдаг "Trade Finance Forum 2024" арга хэмжээ, EuroChamber Mongolia-ийн арга хэмжээ, UN-Day 2024 зэрэгт дэмжлэг үзүүлж, идэвхтэй оролцож ажиллалаа.

АЖИЛТНУУДЫН ҮНЭЛЭМЖ, БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ:

Банкны амжилтын түлхүүр, хамгийн үнэ цэнтэй капитал болох нийт ажилтнуудынхаа уйгагүй хичээл зүтгэл, байгууллагын өсөлтөд оруулсан бодит хувь нэмрийг өндрөөр үнэлж, авьяаслаг боловсон хүчнээ тогтвортой ажиллуулан, урамшуулах бодлогынхоо хүрээнд гүйцэтгэх удирдлагаас бусад ажилтнуудын бүтээмжийн цалинг 25 хүртэлх хувиар нэмэгдүүлэх чухал шийдвэрийг гаргасан нь бидний зүгээс ажилтнууддаа талархал илэрхийлж буйн нэгээхэн хэлбэр гэж үзэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь Худалдаа, хөгжлийн банк 2024 онд өөрийн стратегийн гурван үндсэн чиглэлийн хүрээнд тодорхой зорилтуудыг амжилттай хэрэгжүүлж, олон улсын тавцанд байр сууриа бэхжүүлэн, харилцагч төвтэй соёлыг гүнзгийрүүлж, технологийн шинэчлэлийг нэвтрүүлснээр тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын манлайллаа бататгаж, бүх оролцогч талуудынхаа өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэн, үнэ цэнийг нэмэгдүүлсэн онцгой үр дүнтэй жил байлаа хэмээн дүгнэж байна. 2024 онд бий болгосон эдгээр бодит амжилтууд нь банкны цаашдын тогтвортой өсөлт, хөгжил дэвшлийн бат бэх үндэс суурь болж, ирээдүйн улам их амжилтад хүрэхэд түлхэц үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2024 онд санхүүгийн үйл ажиллагааны хувьд онцгой амжилт гаргаж, цэвэр ашгаа өмнөх оноос 97.5 хувиар өсгөн 298.6 тэрбум төгрөгт хүргэлээ. Энэхүү өндөр өсөлтөд банкны үндсэн орлогын сувгууд болох хүүгийн орлого 42.0 хувиар, шимтгэл хураамжийн орлого 24.8 хувиар тус тус эрчимтэй нэмэгдсэнээс гадна, зээлийн багцын чанарыг сайжруулах чиглэлээр авсан арга хэмжээний үр дүнд чанаргүй зээлийн хэмжээг 54.3 хувиар мэдэгдэхүйц бууруулж ажиллаж чадсан нь голлон нөлөөлөв. Мөн банкны 3 сегмент болох байгууллага, ЖДБ, иргэдийн сегментийн зээлийн багцуудын нийт багцад эзлэх хувийг 50/20/30 хувь болгох, эрсдэлээр жигнэсэн активын эзлэх хувийг 60/18/22 хувь болгох зорилтдоо хүрснээр төвлөрлийн эрсдэлийг бууруулж цаашдын бизнесийн өсөлтийн стратегийг хангаж ажиллаа.

Банкны нийт актив 23.3 хувиар өсөж, 15.0 их наяд төгрөгт хүрсэн нь тогтвортой өсөлтийг харуулж байна. Үүний зэрэгцээ, банкны санхүүгийн чадавх, тогтвортой байдлын илэрхийлэл болсон өөрийн хөрөнгийн хэмжээ 14.7 хувиар өсөж, 1.6 их наяд төгрөгт хүрсэн нь цаашдын өсөлт, хөгжлийн бат бэх суурийг улам бэхжүүллээ. Банкны зүгээс тогтвортой өсөлтийг хадгалахын зэрэгцээ эрсдэлийг оновчтой удирдах зорилтын хүрээнд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг 49.5 хувиар найдвартай түвшинд барьж санхүүгийн тогтвортой байдлыг ханган ажиллалаа.

ХХБ нь 2024 оны эцсийн байдлаар Монгол Улсын банкны салбарын нийт активын 21.3 хувь (15.0 их наяд төгрөгийн активаараа), нийт зээлийн 19.2 хувь, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 21.1 хувь, нийт ашгийн 11.9 хувийг дангаараа бүрдүүлсэн нь банкны системийн нөлөө бүхий, тэргүүлэгч банкны байр сууриа тодотгон харуулсаар байна.

Эдгээр үзүүлэлтүүдээрээ ХХБ нь Монгол Улсын эдийн засаг, банкны салбарт эзлэх тэргүүлэх байр сууриа бататгаж, дотооддоо төдийгүй олон улсад нэр хүндтэй, найдвартай түнш болохоо дахин нотлон харуулсан амжилттай жил байсан төдийгүй ТУЗ-ийн гишүүдийн банкийг үнэлсэн үнэлгээний дунджаар 2024 онд үйл ажиллагаа хэвийн буюу “Сайн” ажилласан гэж дүгнэж байна.

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 ОНЫ НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТЫН ТАЙЛАН

№	Ногдол ашиг олгох тухай тогтоол	Хувьцааны тоо, ширхэг	Нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг (төгрөг)	Ногдол ашгийн дүн (төгрөг)
1	2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 25 тоот тогтоол	50,600,927	1,033.00	52,270,757,591
2	2024 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 49 тоот тогтоол	50,600,927	1,033.00	52,270,757,591

БАНКНЫ 2024 ОНЫ ЦЭВЭР АШГААС НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН НЭГЖ ЭНГИЙН ХУВЬЦААНД НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Банкны Төлөөлөн удирдах зөвлөл 2025 оны 2 дугаар сарын 13-ны өдөр хуралдаж, “Банкны 2024 оны санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсны дараах цэвэр ашгаас нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд ногдол ашиг хуваарилах”-аар шийдвэрлэсэн.



TDB
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

TRADE AND DEVELOPMENT BANK OF MONGOLIA
REPRESENTATIVE GOVERNING BOARD RESOLUTION

2025 оны 02 сарын 13 өдөр Дугаар 03 Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Банкны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэг болон “Худалдаа, хөгжлийн банк” ХК (цаашид “Банк” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.16 дахь заалт болон 13 дугаар зүйлийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Банкны 2024 оны санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсны дараах цэвэр ашгаас нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсүгэй.

2. Банкны 2024 оны санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсны дараа нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахтай холбоотой бусад асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА **РАНДОЛФ КОППА**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

Ж.БОЛОРМАА

35+ жилийн туршлага

БОЛОВСРОЛ

- ОХУ, Иванова хотын Нэхмэлийн Дээд Сургууль
- БНСУ, Хандоны Их Сургууль /СЭЗИС/, Бизнесийн удирдлагын магистр

ТУРШЛАГА

- 1987 - 1990 онд Говь компанид мастер;
- 1990 - 1994 онд Худалдаа, Аж Үйлдвэрийн Дээд Сургууль, Эрдэм шинжилгээний ажилтан, багш;
- 1996 - 2007 онд МХБ, ажилтан;
- 2007 - 2015 онд СЗХ, Ахлах хянан шалгагч, газрын дарга;
- 2015 - 2018 онд Амаржаргал сан, ТУЗ-ийн дарга;
- 2015 оноос одоог хүртэл Ламын гэгээ монгол сүнчой ТББ, ТУЗ-ийн гишүүн;
- 2017 оноос одоог хүртэл ХХБ, ТУЗ-ийн хараат бус гишүүн.

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-Д ЭЗЭМШИЖ БУЙ ХУВЬЦААНЫ ХЭМЖЭЭ

Хувьцаа эзэмшдэггүй.

Ж.ДЭЛГЭРСАЙХАН

30 жилийн туршлага

БОЛОВСРОЛ

- ХААИС, Эдийн засагч;
- СЭЗИС, Санхүүгийн магистр;
- МУИС, Хууль-эрх зүйч;
- Удирдлагын академи, Төрийн удирдлагын доктор;

ТУРШЛАГА

- 1995 – 2019 онд Машин механизм ХК, ТУЗ – ийн гишүүн, дарга;
- 1996 оноос одоог хүртэл СЭЗИС-д Багш, тэнхимийн эрхлэгч, зөвлөх;
- 1998 – 2000 онд Эм энд Жи Траст ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2006 – 2007 онд Машин механизм ХК, Гүйцэтгэх захирал;
- 2007 – 2009 онд Кибернетик ББСБ, Зөвлөх, Дэд захирал;
- 2017 оноос одоог хүртэл ХХБ, ТУЗ-ийн хараат бус гишүүн;
- 2024 оноос одоог хүртэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, гишүүн

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-Д ЭЗЭМШИЖ БУЙ ХУВЬЦААНЫ ХЭМЖЭЭ

Хувьцаа эзэмшдэггүй.

Г.БАТЖАРГАЛ

20+ жилийн туршлага

БОЛОВСРОЛ

- МУИС – Эдийн засгийн сургуул, “Банк” бакалавр;
- МУИС – Эдийн засгийн сургууль, Бизнесийн удирдлагын магистр

ТУРШЛАГА

- 2004-2010 - Монгол шуудан банк, дилер, ахлах дилер;
- 2010-2013 – Хадгаламж банк ахлах дилер, хэлтсийн захирал;
- 2013-2014 – Төрийн банк, Арилжааны хэлтсийн захирал;
- 2014-2020 – Улаанбаатар хотын банк, Хөрөнгө зохицуулалтын газрын захирал;
- 2020-2021 – худалдаа, хөгжлийн банк, Арилжааны хэлтсийн захирал;
- 2021 оноос одоог хүртэл Мони маркет фанд ХХК, Гүйцэтгэх захирал

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-Д ЭЗЭМШИЖ БУЙ ХУВЬЦААНЫ ХЭМЖЭЭ

0.00%

Г.Батжаргалын бүрэн эрхийн хугацаа
2025 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхэлнэ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

РАНДОЛФ КОППА

55+ жилийн туршлага

БОЛОВСРОЛ

- АНУ-ын Висконсин мужийн Мэдисоны Их Сургууль, Олон улсын харилцаа;

ТУРШЛАГА

- 1966 – 2004 онд 12 орны банк, санхүүгийн байгууллагад удирдах албан тушаалд, үүнээс 16 жилд нь ING банканд ажиллаж байсан арвин туршлагатай;
- 2004 – 2016 онд ХХБ, Гүйцэтгэх захирал, Ерөнхийлөгч;
- 2006 – 2013 онд МИК, ТУЗ-ийн дарга
- 2013 оноос одоог хүртэл Business Council of Mongolia, ТУЗ-ийн дарга;
- 2016 – 2022 онд ХХБ, ТУЗ-ийн гүйцэтгэх дэд дарга;
- 2022 оноос одоог хүртэл American Chamber of Commerce, ТУЗ-ийн гишүүн, ТУЗ-ийн дарга;
- 2022 оноос одоог хүртэл ХХБ, ТУЗ-ийн дарга.

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-Д ЭЗЭМШИЖ БҮЙ ХУВЬЦААНЫ ХЭМЖЭЭ

Хувьцаа эзэмшдэггүй.

Д.ЭРДЭНЭБИЛЭГ

30+ жилийн туршлага

БОЛОВСРОЛ

- МУИС, Эрх зүйч;
- Монгол Улсын Удирдлагын Академи, Улс төр судлалын магистр;
- СЭЗИС, Банк, санхүү.

ТУРШЛАГА

- 2003 – 2006 онд Улаанбаатар хотын банк, ТУЗ-ийн дарга;
- 2006 – 2022 онд ХХБ, ТУЗ-ийн дарга;
- 2022 оноос одоог хүртэл ХХБ, ТУЗ-ийн гишүүн.

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-Д ЭЗЭМШИЖ БҮЙ ХУВЬЦААНЫ ХЭМЖЭЭ

Хувьцаа эзэмшдэггүй.

Д.ХҮРЭЛБААТАР

40+ жилийн туршлага

БОЛОВСРОЛ

- Худалдааны техникум, Нягтлан бодогч;
- ОХУ, Эрхүү хотын УААДС, Банкны эдийн засагч;
- Эрхүүгийн Марксизм Ленинизмийн Дээд Сургууль, Улс төрийн ажилтан.

ТУРШЛАГА

- 1981 – 1991 онд Улсын банканд Улсын байцаагч, нягтлан бодогч;
- 1991 – 2005 онд ХХБ, Газар, хэлтсийн захирал;
- 2005 – 2007 онд Монгол шуудан банк, Дэд захирал;
- 2007 – 2021 онд ХХБ, Гүйцэтгэх захирлын орлогч, ТУЗ-ийн ажлын албаны дарга;
- 2020 оноос одоог хүртэл ХХБ, ТУЗ-ийн гишүүн;
- 2022 оноос одоог хүртэл Говь ХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн.

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-Д ЭЗЭМШИЖ БҮЙ ХУВЬЦААНЫ ХЭМЖЭЭ

Хувьцаа эзэмшдэггүй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Д.ЯНЖМАА

45+ жилийн туршлага

БОЛОВСРОЛ

- Санхүүгийн Техникум, Банкны нягтлан бодогч;
- МУИС, УААА-ны салбарын нягтлан бодогч, эдийн засагч.

ТУРШЛАГА

- 1977 – 1990 онд Улсын банк, Нягтлан бодогч, Ахлах нягтлан бодогч;
- 1990 – 2003 онд ХХБ, Санхүүгийн газар, нэгжийн захирал;
- 2004 – 2007 онд Монгол шуудан банк, Санхүүгийн газрын захирал;
- 2007 – 2019 онд ХХБ, Санхүүгийн удирдлага, хяналтын газрын захирал;
- 2019 оноос одоог хүртэл ХХБ, ТУЗ-ийн гишүүн.

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-Д ЭЗЭМШИЖ БУЙ ХУВЬЦААНЫ ХЭМЖЭЭ

Хувьцаа эзэмшдэггүй.

А.ЭНХМЭНД

25+ жилийн туршлага

БОЛОВСРОЛ

- ШУТИС, Инженер-технологич;
- ШУТИС, Инженер-технологич, магистр;
- СЭЗИС, Нягтлан бодогч – эдийн засагч.

ТУРШЛАГА

- 2004 - 2005 онд Интер банк, Дэд захирал, Гүйцэтгэх захирал;
- 2005 - 2020 онд Улаанбаатар хотын банк, Тэргүүн дэд захирал, Гүйцэтгэх захирал;
- 2020 оноос одоог хүртэл ХХБ, Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч;
- 2023 оноос ХХБ, ТУЗ-ийн гишүүн

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-Д ЭЗЭМШИЖ БУЙ ХУВЬЦААНЫ ХЭМЖЭЭ

Хувьцаа эзэмшдэггүй.

Д.ОТГОНБИЛЭГ

25+ жилийн туршлага

БОЛОВСРОЛ

- МУИС - ЭЗДС, Эдийн засагч;
- МУИС - ЭЗС, Бизнесийн удирдлагын магистр.

ТУРШЛАГА

- 1997 - 1999 онд Сэргээн босголтын банк, Эдийн засагч;
- 1999 - 2001 онд Хадгаламж банк, нягтлан бодогч, Хянан шалгагч;
- 2001 - 2005 онд Интер банк ахлах ажилтан (Дотоод аудит);
- 2005 - 2007 онд Улаанбаатар хотын банк Дотоод аудитын газрын ахлах ажилтан, газрын захирал;
- 2007 - 2008 онд ХХБ, Дотоод аудитын газрын захирал;
- 2008 - 2011 онд ХХБ, Эрсдэлийн удирдлагын газрын захирал;
- 2011 - 2021 онд ХХБ, Гүйцэтгэх захирлын орлогч;
- 2021 оноос одоог хүртэл МИК ОССК ХХК, Дэд захирал;
- 2023 оноос одоог хүртэл ХХБ, ТУЗ-ийн гишүүн.

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-Д ЭЗЭМШИЖ БУЙ ХУВЬЦААНЫ ХЭМЖЭЭ

0.00%

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

___ он ___ сар ___ өдөр Дугаар ____ Улаанбаатар хот

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6, 29.2.7 дахь заалт, "Худалдаа, хөгжлийн банк" ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.9 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Худалдаа, хөгжлийн банкны 2024 оны жилийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Хавсралтын дагуу баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА РАНДОЛФ КОППА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Н.НЯМСҮРЭН

Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн
2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит
хурлын 01 тоот тогтоолын хавсралт

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГСӨН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

Монголын банкны салбар 2024 онд өмнөх оны томоохон өөрчлөлт, шинэчлэлтүүдийн үр нөлөөг бататган, цаашдын тогтвортой хөгжлийн суурийг бэхжүүлэхэд анхаарсан жил байлаа. Худалдаа, хөгжлийн банк (ХХБ) нь нээлттэй хувьцаат компани болсон статусаа ашиглан, засаглал, ил тод байдлаа улам сайжруулж, зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг идэвхтэй явуулсаар байна. Банкны салбар ерөнхийдөө өсөлтөө хадгалахын зэрэгцээ, дижитал шилжилт, эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох зэрэгт түлхүү анхаарсан нь 2024 оны онцлог байв.

ХХБ нь нээлттэй хувьцаат компани болсноор бэхэжсэн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн бүрэлдэхүүн 2024 онд банкны стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэв. Өргөтгөсөн, олон талт ур чадвартай ТУЗ нь банкны бизнесийн тасралтгүй өсөлтийг дэмжих, эрсдэлийн удирдлагын оновчтой тогтолцоог хэвшүүлэх, дотоодын болон олон улсын шилдэг туршлага, стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд чиглэсэн стратегийн удирдамж, зөвлөмжөөр тогтмол хангаж ажиллалаа. ТУЗ нь 2024 оны турш Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Банкны зохистой засаглалын зарчмууд болон ХХБ-ны дүрмийг үйл ажиллагааныхаа үндэс болгон, ТУЗ болон түүний дэргэдэх хороодын тогтоол, шийдвэрээр дамжуулан банкны үйл ажиллагааг чиглүүлж, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын эрх ашгийг дээдлэн, тэдний үнэ цэнийг өсгөхөд онцгой анхаарал хандуулав.

Банкны 2024 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлт нь ХХБ-ны урт болон дунд хугацааны стратегийн хэрэгжилт, тухайн жилийн батлагдсан санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд ТУЗ-ийн гишүүдийн хийсэн хараат бус, бодит үнэлгээнд суурилсан болно.

2024 онд ХХБ-ны Гүйцэтгэх удирдлагын баг болон нийт ажилтнууд ТУЗ-өөс баталсан стратегийн чиглэлийн дагуу банкны урт хугацааны зорилтууд болох:

- Харилцагч төвтэй байдлаа улам гүнзгийрүүлэх,
- Олон улсын зах зээл дэх байр сууриа бэхжүүлэх,
- Технологийн дэвшилд суурилсан, шинэлэг үйлчилгээ бүхий платформ банк болох алсын хараг хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллалаа. Эдгээр хүчин чармайлтын үр дүнд банкны актив, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, зах зээлд эзлэх байр сууриа бэхжүүлэх чиглэлээр төлөвлөгөөт зорилтуудыг ханган биелүүлэхээр хичээнгүйлэн ажилласан гэдэгт итгэлтэй байна.

2024 он нь стратегийн зорилтуудаа амжилттай ахиулж, зах зээл дэх манлайлал, олон улсын тавцан дахь нэр хүндээ улам бататган, инноваци, тогтвортой хөгжлийн чиглэлээр бодитой үр дүнд хүрсэн онцгой жил байлаа. Банкны урт хугацааны стратегийн гурван тулгуур чиглэлийн хүрээнд Гүйцэтгэх удирдлага болон нийт ажилтнуудын хүчин чармайлтаар 2024 онд дараах томоохон амжилтад хамтын хүчээр бид хүрлээ.

ХАРИЛЦАГЧ ТӨВТЭЙ БАНК БОЛОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Банкны бүх үйл ажиллагааны төвд харилцагчийг тавьж, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн, орчин үеийн, хүртээмжтэй, найдвартай үйлчилгээг хүргэхэд онцгой анхаарал хандуулж, харилцагчийн туршлагыг тасралтгүй сайжруулж, ажиллалаа. Харилцагчдадаа дэлхийн жишигт нийцсэн, хялбар, аюулгүй төлбөрийн шийдлийг санал болгох зорилгоор ApplePay үйлчилгээг Монгол Улсад анхлан амжилттай нэвтрүүлж, дижитал төлбөр тооцооны шинэ боломжийг нээлээ. Харилцагчийн картын болон хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг олон улсын дээд түвшний стандартад нийцүүлэн ажиллаж байна. Харилцагчдад үйлчлүүлэх таатай, орчин үеийн орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор үндэсний шилдэг компаниудын нэг A1 Architects-тэй хамтран банкны салбаруудын дотоод интерьер, тохижилтыг шинэчлэх ажлыг эхлүүлж, үйлчилгээний чанарт бодит хөрөнгө оруулалт хийлээ.

ОЛОН УЛСЫН БАНК БОЛОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

ХХБ нь олон улсын санхүүгийн зах зээлд Монгол Улсын болон өөрийн банкны нэр хүндийг өсгөх, дэлхийн жишигт нийцсэн үйл ажиллагаа явуулах, гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх чиглэлээр 2024 онд томоохон алхмуудыг хийлээ. АНУ-ын Bank of New York Mellon-той тогтоосон ам.долларын ностро дансны харилцаагаа бататгаж, Монгол Улсыг дэлхийн ам.долларын төлбөрийн системд найдвартай, тасралтгүй холбох үүргээ амжилттай гүйцэтгэв. Түүхэн амжилт болгож, Монголын банк санхүүгийн байгууллагаас анх удаа АНУ-ын Засгийн газрын агентлаг болох Олон Улсын Хөгжлийн Санхүүжилтийн Корпорац (DFC)-аас шууд урт хугацааны санхүүжилт татсан нь Монгол Улсын бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, эмэгтэй бизнес эрхлэгчдийн өсөлт болон уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулах чухал эх үүсвэр болов. Мөн Австри Улсын Венийн хөрөнгийн бирж дээр олон улсын мэргэжлийн хөрөнгө оруулагчдад зориулан Монгол Улсаас анх удаа Нийгмийн болон Ногоон бондыг амжилттай гаргаж, дэлхийн топ 10-т багтдаг Ассет Менежмент компаниас хөрөнгө оруулалт татсан нь олон улсын тогтвортой санхүүжилтийн зах зээлд нэвтрэх шинэ гарцыг нээлээ. Эдгээр амжилтууд нь банкны санхүүгийн тогтвортой байдал, зөв засаглалын илрэл болж, олон улсын зэрэглэл тогтоогч Moody's агентлагаас ХХБ-ны зээлжих зэрэглэлийг B2 “Тогтвортой” түвшинд ахиулахад эерэгээр нөлөөлөв.

ПЛАТФОРМ БАНК БОЛОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа үр дүнтэй нэвтрүүлж, банкны үйлчилгээний хүртээмж, үр ашиг, найдвартай байдлыг нэмэгдүүлэхэд чухал ахиц дэвшил гаргалаа. Төлбөрийн картын аюулгүй байдлын олон улсын PCI DSS 4.0 стандартыг амжилттай хангаж, 8 дахь жилдээ харилцагчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Банкны үйлчилгээг газарзүйн байршлаас үл хамааран хүргэх, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Агент банкны үйлчилгээг амжилттай нэвтрүүлж, банкны үйлчилгээг иргэдэд илүү ойртуулсан шинэлэг сувгийг бий болгов. Харилцагч, олон нийтэд зориулсан мэдээллийн гол суваг болох банкны вебсайтыг Канад улсын Image X компанитай хамтран орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилж, дижитал орчин дахь хэрэглэгчийн туршлагыг сайжруулав.

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА ХАМТЫН ҮНЭ ЦЭН БҮТЭЭХ:

ХХБ нь тогтвортой хөгжлийн зорилтуудыг үйл ажиллагаандаа тууштай хэрэгжүүлж, эдийн засгийн тулгуур хүч болсон жижиг, дунд бизнес (ЖДБ)-ийг идэвхтэй дэмжлээ. Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-тэй хамтран ЖДБ-ийг дэмжих "SFME" төслийг хэрэгжүүлэх гэрээ байгуулж, Дижитал Кредит ХХК-тай хамтын ажиллагаа эхлүүлэв. Түүнчлэн, Ханбогдын Хөгжлийн Хурдасгуур Оюу Толгойн сан, Даян дэлхийн ногоон хөгжлийн институт (GGGI), Нийслэлийн ЖДҮҮ-г Дэмжих Төв, Зээлийн Батлан Даалтын Сан зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг, гэрээ хэлэлцээрүүдийг байгуулж, бүс нутгийн ногоон хөгжил, ЖДБ-ийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал алхмууд хийлээ. Анх удаа эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан "BE LADY" форумыг амжилттай зохион байгуулж, жендэрийн тэгш байдлыг дэмжих чиглэлээр хийсэн ажлуудаараа Тогтвортой Санхүүжилтийн Холбооноос "Жендерийн Манлай Байгууллага"-аар шалгарав. Мөн уламжлал болгон зохион байгуулдаг "Trade Finance Forum 2024" арга хэмжээ, EuroChamber Mongolia-ийн арга хэмжээ, UN-Day 2024 зэрэгт дэмжлэг үзүүлж, идэвхтэй оролцож ажиллалаа.

АЖИЛТНУУДЫН ҮНЭЛЭМЖ, БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ:

Банкны амжилтын түлхүүр, хамгийн үнэ цэнтэй капитал болох нийт ажилтнуудынхаа уйгагүй хичээл зүтгэл, байгууллагын өсөлтөд оруулсан бодит хувь нэмрийг өндрөөр үнэлж, авьяаслаг боловсон хүчнээ тогтвортой ажиллуулан, урамшуулах бодлогынхоо хүрээнд гүйцэтгэх удирдлагаас бусад ажилтнуудын бүтээмжийн цалинг 25 хүртэлх хувиар нэмэгдүүлэх чухал шийдвэрийг гаргасан нь бидний зүгээс ажилтнууддаа талархал илэрхийлж буйн нэгээхэн хэлбэр гэж үзэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь Худалдаа, хөгжлийн банк 2024 онд өөрийн стратегийн гурван үндсэн чиглэлийн хүрээнд тодорхой зорилтуудыг амжилттай хэрэгжүүлж, олон улсын тавцанд байр суурьиа бэхжүүлэн, харилцагч төвтэй соёлыг гүнзгийрүүлж, технологийн шинэчлэлийг нэвтрүүлснээр тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын манлайллаа бататгаж, бүх оролцогч талуудынхаа өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэн, үнэ цэнийг нэмэгдүүлсэн онцгой үр дүнтэй жил байлаа хэмээн дүгнэж байна. 2024 онд бий болгосон эдгээр бодит амжилтууд нь банкны цаашдын тогтвортой өсөлт, хөгжил дэвшлийн бат бэх үндэс суурь болж, ирээдүйн улам их амжилтад хүрэхэд түлхэц үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2024 онд санхүүгийн үйл ажиллагааны хувьд онцгой амжилт гаргаж, цэвэр ашгаа өмнөх оноос 97.5 хувиар өсгөн 298.6 тэрбум төгрөгт хүргэлээ. Энэхүү өндөр өсөлтөд банкны үндсэн орлогын сувгууд болох хүүгийн орлого 42.0 хувиар, шимтгэл хураамжийн орлого 24.8 хувиар тус тус эрчимтэй нэмэгдсэнээс гадна, зээлийн багцын чанарыг сайжруулах чиглэлээр авсан арга хэмжээний үр дүнд чанаргүй зээлийн хэмжээг 54.3 хувиар мэдэгдэхүйц бууруулж ажиллаж чадсан нь голлон нөлөөлөв. Мөн банкны 3 сегмент болох байгууллага, ЖДБ, иргэдийн сегментийн зээлийн багцуудын нийт багцад эзлэх хувийг 50/20/30 хувь болгох, эрсдэлээр жигнэсэн активын эзлэх хувийг 60/18/22 хувь болгох зорилтоо хүрснээр төвлөрлийн эрсдэлийг бууруулж цаашдын бизнесийн өсөлтийн стратегийг хангаж ажиллалаа.

Банкны нийт актив 23.3 хувиар өсөж, 15.0 их наяд төгрөгт хүрсэн нь тогтвортой өсөлтийг харуулж байна. Үүний зэрэгцээ, банкны санхүүгийн чадавх, тогтвортой байдлын илэрхийлэл болсон өөрийн хөрөнгийн хэмжээ 14.7 хувиар өсөж, 1.6 их наяд төгрөгт хүрсэн нь цаашдын өсөлт, хөгжлийн бат бэх суурийг улам бэхжүүллээ. Банкны зүгээс тогтвортой өсөлтийг хадгалахын зэрэгцээ эрсдэлийг оновчтой удирдах зорилтын хүрээнд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг 49.5 хувиар найдвартай түвшинд барьж санхүүгийн тогтвортой байдлыг ханган ажиллалаа.

ХХБ нь 2024 оны эцсийн байдлаар Монгол Улсын банкны салбарын нийт активын 21.3 хувь (15.0 их наяд төгрөгийн активаараа), нийт зээлийн 19.2 хувь, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 21.1 хувь, нийт ашгийн 11.9 хувийг дангаараа бүрдүүлсэн нь банкны системийн нөлөө бүхий, тэргүүлэгч банкны байр сууриа тодотгон харуулсаар байна.

Эдгээр үзүүлэлтүүдээрээ ХХБ нь Монгол Улсын эдийн засаг, банкны салбарт эзлэх тэргүүлэх байр сууриа бататгаж, дотооддоо төдийгүй олон улсад нэр хүндтэй, найдвартай түнш болохоо дахин нотлон харуулсан амжилттай жил байсан төдийгүй ТУЗ-ийн гишүүдийн банкийг үнэлсэн үнэлгээний дунджаар 2024 онд үйл ажиллагаа хэвийн буюу “Сайн” ажилласан гэж дүгнэж байна.

___ он ___ сар ___ өдөр Дугаар ____ Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.8 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг болон "Худалдаа, хөгжлийн банк" ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.10 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь**:

1. Дараах нэр дэвшигчдийг Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгон томилсугай.

1.1. ... ;
1.2. ... ;
1.3. ... .

2. Дараах нэр дэвшигчдийг Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгон томилсугай.

2.1. ... ;
2.2. ... ;
2.3. ... ;
2.4. ... ;
2.5. ... ;
2.6. ... .

3. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнөх бүрэлдэхүүний бүрэн эрх дуусгавар болж чөлөөлөгдсөн болохыг дурдсугай.

3.1. Жалбаагийн Болормаа;
3.2. Жамсрандоржийн Дэлгэрсайхан;
3.3. Загдхүүгийн Нарантуяа /2024 оны 11 дүгээр сарын 4-ний өдрөөс/;
3.4. Рандолф Коппа;
3.5. Должингийн Эрдэнэбилэг;
3.6. Дагмидын Янжмаа;
3.7. Дамбийжавын Хүрэлбаатар;
3.8. Авгааны Энхмэнд;
3.9. Дэмчигжавын Отгонбилэг.

4. Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс болон бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын дүрэм, журам, заавар, Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад шаардлагатай дүрэм, журам, зааврыг чанд баримтлан ёс зүйтэй, хариуцлагатай ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА РАНДОЛФ КОППА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Н.НЯМСҮРЭН

___ он ___ сар ___ өдөр Дугаар ____ Улаанбаатар хот

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, "Худалдаа, хөгжлийн банк" ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.11 дэх заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025-2026 оны буюу дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрийг хүртэлх зардлын төсвийг 6,000,000,000.00 (зургаан тэрбум) төгрөгөөр баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА РАНДОЛФ КОППА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Н.НЯМСҮРЭН

TDB ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 12 тоот тогтоолын Хавсралт 5-аар "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас"-ын агуулга, загварыг батлав.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС

Компанийн оноосон нэр: "Худалдаа, хөгжлийн банк" ХК

Компанийн хаяг: Улаанбаатар хот, 14210, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, Худалдаа, хөгжлийн банкны төв байр

Хурал хуралдах газар, өдөр: 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 9:00 цагт
Худалдаа, хөгжлийн банкны боловсруулсан цахим хуудас болох investor.tdbm.mn-ээр дамжуулан цахим болон зайны технологи ашиглан хуралдуулах.

Санал өгөх ерөнхий заавар:

- Хувьцаа эзэмшигч нь хурлын бүртгэлийн өдөр буюу 2025 оны 4 дүгээр сарын 7-ний өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор санал өгнө.
- Тэмдэглэгээ хийгээгүй, засварласан, балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд урьдчилан санал хүргүүлэхдээ Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 17:00 цаг хүртэл холбогдох зааврын дагуу investor.tdbm.mn цахим хуудсанд хандан цахим хэлбэрээр эсхүл Худалдаа, хөгжлийн банкны төв байранд цаасан хэлбэрээр Тооллогын комисст хүлээлгэн өгнө.
- Хувьцаа эзэмшигч хувь хүн нь өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулж, энэхүү саналын хуудаст хавсаргана.
- Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, хувьцаа эзэмшигчийн хуралд төлөөлөн оролцох эрх бүхий этгээдийг томилсон шийдвэр (Хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэр эсхүл Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоол гэх мэт)-ийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн иргэний үнэмлэхийн хуулбарыг энэхүү саналын хуудаст хавсаргана.

Хувьцаа эзэмшигчийн эцэг/эхийн нэр, нэр:	
Хувьцаа эзэмшигчийн утасны дугаар:	
Хувьцаа эзэмшигчийн цахим шуудангийн хаяг:	
Регистрийн дугаар:	
Эзэмшиж буй хувьцааны төрөл:	Энгийн
Эзэмшиж буй хувьцааны тоо:	

Санал хураах арга: Ердийн

Ердийн аргаар санал өгөх заавар: Саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож, өөрийн сонгож буй саналын нүдэнд (✓) эсхүл (+) тэмдэг тавина.

№	Хэлэлцэх асуудал	Хувьцаа эзэмшигчийн санал		
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай			
2	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай			

Санал хураах арга: Кумулятив

Кумулятив аргаар санал өгөх заавар:

- Кумулятив аргыг хэрэглэхэд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн 1 (нэг) хувьцаа нь 9 Саналын эрхтэй байна.
- Хувьцаа эзэмшигч саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүтгийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.
- **Жишээ нь:** Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцаат эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно.

  Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүтгийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.

  Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

№	Нэр дэвшигчийн овог, нэр	Кумулятив саналын тоо
Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчийг сонгох		
1	ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Жалбаагийн Болормаг сонгох тухай	
2	ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Жамсрандоржийн Дэлгэрсайханыг сонгох тухай	
3	ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Гэлэгжамцын Батжаргалыг сонгох тухай	
Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчийг сонгох		
1	ТУЗ-ийн гишүүнээр Рандолф Коппаг сонгох тухай	
2	ТУЗ-ийн гишүүнээр Должингийн Эрдэнэбилэгийг сонгох тухай	
3	ТУЗ-ийн гишүүнээр Дагмидийн Янжмаагаг сонгох тухай	
4	ТУЗ-ийн гишүүнээр Дамбийжавын Хүрэлбаатарыг сонгох тухай	
5	ТУЗ-ийн гишүүнээр Авгааны Энхмэндийг сонгох тухай	
6	ТУЗ-ийн гишүүнээр Дэмчигжавын Отгонбилэгийг сонгох тухай	

Заавар чилгаа:
Хувьцаа эзэмшигч та хувь хүн бол "Хувьцаа эзэмшигч хувь хүн бөглөнө." хэсэгт, хуулийн этгээдийг төлөөлөн оролцож буй бол "Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд бөглөнө." хэсэгт гарын үсэг зурах шаардлагагүй анхаарна уу.

Хувьцаа эзэмшигч хувь хүн бөглөнө. Хувьцаа эзэмшигчийн Нэр: ..... Гарын үсэг:	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд бөглөнө. Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн Нэр: ..... Албан тушаал: ..... Гарын үсэг: .....
2025 оны ... -р сарын ...-ны өдөр	
Тооллогын комисс бөглөх хэсэг:	
Саналын хуудсыг хүлээлгэн авсан огноо, цаг:	
Саналын хуудсыг хүлээн авсан Тооллогын комиссын гишүүний нэр, гарын үсэг:	

Саналын хуудсыг хүчинтэй тооцон тоолсон эсэх (доогуур зурах): *Тийм* *Үгүй*

Комиссын дарга: ..... / /

Саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл:

.....

Утас: +976 1900-1977
И-мэйл: info@tdbm.mn
Вэб хаяг: www.tdbm.mn
/// бахдал.эрдэнэс.мэдрэгч